Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

“Дундаас дээш түвшний хурдтай шинэчлэл”

Ядуурлыг бууруулах зэвсэг

Монголын эдийн засаг, бизнесийн сэтгүүл 2013 он. 12 сар. №23 (057) www.mongolianeconomy.mn

ТОМ ТӨРД СӨГДСӨН БИЗНЕС



Шог зургийг А.Амарсайхан

XacBank
Зөв Банк



ХАСБАНК МОНГОЛ УЛСЫН ШИЛДЭГ БАНКААР ШАЛГАРЛАА


www.thebanker.com www.xacbank.mn

Мэдээллийн нэгдсэн сан

* Logo3s.mn
* Reclam6s.mn
* Mobile web
* Application
  /App store, Playstore/
* Реклам мэдээллийн сан
* Media сурталчилгаа











Эдгээр нэгдсэн цахим үйлчилгээ нь та хаана ч явж байсан гар утас болон мэдээллийн touch дэлгэцнээс өөрийн шаардлагатай мэдээллийг мобайл вэб, вэб сайт ба аппликейшнээс татан авч үзэх, мөн өөрийн үйл ажиллагааг сурталчилах зэрэг олон үйлчилгээг зэрэгцэн үзүүлэх хосолсон ажиллагаа юм.

Иймээс нэгдсэн цахим үйлчилгээ нь таны цаг хугацаа, мөнгө санхүүг хэмнэхийн зэрэгцээ танд амжилтыг дагуулсан алтан хөтөч байх болно.

Утас: 7010-0156, 9111-6586

Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:
Д.Бэхбаяр /9999-4248/

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:
И.Отгонжаргал /8800-6228/

ЕРӨНХИЙ РЕДАКТОР:
Б.Цогзаяабаатар /9919-0715/

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:
Теренс Эдвардс

ОРЧУУЛАГЧ: Р.Гантулга

СЭТГҮҮЛЧИД:
Б.Баяртогтох
Э.Зоригт
Х.Хулан
Б.Үүрийнтуяа
Б.Бямбадорж

ДИЗАЙНЕР: Ш.Оюундарь
ВЭБ МАСТЕР: Н.Гал

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:
Д.Бариажав /9409-2904/
Д.Баттулга /9409-2905/

БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖЕР:
М.Хишигтогтох /9409-2906/

“ECONOMY” ТВ СТУДИ

РЕДАКТОР: Ж.Баяржаргал
ЗУРАГЛААЧ: Ш.Гантуул
КОМПЬЮТЕР ГРАФИКЧ: Т.Баярсайхан

ОНЛАЙН ЗАХИАЛГЫГ

http://mongolianeconomy.imedia.mn/

АГУУЛГА

БИЗНЕС

8 Шинэчлэлийн салхи

10 “Дундаас дээш түвшний хурдтай шинэчлэл”

13 Алга ташилтын ард

15 Бизнесийнхний итгэл хэр байна вэ

17 Өчигдөр, маргаашийн үлгэрийн ертөнц: Уолт Дисней

20 Авлигын эсрэг сонголт

24 Ядуурлыг бууруулах зэвсэг

27 Импортыг орлох үйлдвэр

29 Эзэгтэй нарын бухимдал

32 Хэрхэн сайн компанитай болох вэ

34 Apple iOS 7: Санах зүйлс

ЭДИЙН ЗАСАГ

36 Тодотголд яарсан төсөв

39 Хүнсний аюулгүй байдал хийгээд буудай

41 Хүчирхэг аж үйлдвэрийг хөгжүүлье

“MONGOLIAN ECONOMY”
СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ



Б.БЯМБАСАЙХАН Монголын бизнесийн зөвлөлийн ТУЗ-ийн дарга, “Mongolian Economy” сэтгүүлийн Зөвлөлийн тэргүүн



Б.БОЛД
“Рио Тинто” компанийн Зэсийн группын Олон улсын үйл ажилллагаа эрхэлсэн Ерөнхийлөгч



С.БЭХБАТ
ЭЗХЯ-ны Инноваци, төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга



Д.ЖАРГАЛСАЙХАН
МІН группын ерөнхийлөгч



Ц.БАТСҮХ
СЭЗДС-ийн Эдийн засгийн тэнхимийн эрхлэгч



Ж.СҮНЖИДМАА
“Пийбоди Энержи” компанийн Монгол дахь хамтын ажиллагаа, олон нийтийн асуудал хариуцсан менежер



Б.ТҮВШИНТӨГС
Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал

ХАЯГ:
Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг. VI хороо,
Их сургуулийн гудамж. AB center. 503 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан, ш/ х-2762
www.mongolianeconomy.mn
info@mongolianeconomy.mn

УТАС/ФАКС: 976 - 7011 5476

“Улаанбаатар принт” ХХК-д хэвлэв
www.ubprint.mn

БОРЛУУЛАХ ЦЭГҮҮД:

"Интер ном"
"Цэцэг төв"
"Минж плаза"
"Алтантүлхүүр" номын дэлгүүр
"Номин" супермаркетийн бүх салбар
"Макс" супермаркетийн бүх салбар
"Фреско" супермаркет
BTSI супермаркет
"Аз орчлон" номын дэлгүүр
"Билэг" их дэлгүүрийн номын тасаг
"Гранд Плаза" дахь супермаркет
"Мир" номын дэлгүүрийн
"Grand plaza"
"Metro mall"
"Sky" супермаркет
"Улаанбаатар" их дэлгүүр дэх салбар
"Max mall" салбарууд

МОНГОЛД:

БАНК, САНХҮҮ

Япон улсын хоёр дахь том банк Sumitomo Mitsui Banking Corporation (SMBC) өнгөрсөн сарын 27-нд Монголд нээлтээ хийлээ. Энэ нь Монголд үүдээ нээсэн Японы анхны банк юм. Манай улсад үйл ажиллагаа явуулж буй дөрөв дэх гадаадын банк болж буй. SMBC нь Монголын дэд бүтэц, уул уурхай гэх мэт томоохон төслүүдэд хөрөнгө оруулах төлөвлөгөөтэй аж. Одоогоор MCS, “Оюутолгой”, “Тавантолгой” зэрэг тэргүүлэх компани болон төрийн байгууллагаас Эрчим хүчний яамтай дэд бүтцийн төсөл дээр хамтран ажиллаж байна.


“The Banker” сэтгүүлээс 2013 оны “Монгол Улсын шилдэг банк”-аар Хасбанкийг тодруулжээ. 86 жилийн түүхэн замналтай тус сэтгүүл нь улс орнуудын шилдэг банкуудыг тодруулахдаа сүүлийн гурван жилийн санхүүгийн үзүүлэлт. Мөн шинээр хэрэгжүүлсэн санал санаачилга, 12-15 сарын хугацаанд зах зээлд давамгайлсан байдал, жижиг, дунд бизнесийг дэмжих чиглэлээр хийсэн ажил зэрэг үндсэн таван асуулгыг банкуудад тавьдаг. Жил бүр зохион байгуулдаг шагнал гардуулах ёслолын ажиллагаа 14 дэх удаагаа Лондон хотноо болсон юм.

ЭРЧИМ ХҮЧ

Эгийн голын 220 мВт хүчин чадалтай усан цахилгаан станц барих ажлыг эрчимжүүлэхээр боллоо. Тус төсөлд эхний ээлжинд шаардлагатай 50 сая ам.долларыг шийдвэрлэжээ. Уг төслийг хэрэгжүүлснээр манай улсын төвийн эрчим хүчний хүчин чадал сайжрах бөгөөд тогтвортой үйл ажиллагааг хангах юм. Станцыг барьснаар жилдээ 10 сая ам.долларыг хэмнэхийн дээр хөрөнгө оруулалтаа 10-15 жилд нөхөх тооцоо гарчээ.

УУЛ УУРХАЙ

Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр /2005/ 2.5 хувь байхад түүхэндээ хамгийн их хэмжээний буюу 24 тонн алт манай улс олборлож байв. Харин “Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хууль” хэрэгжиж эхэлснээс хойш алтны олборлолт жил дараалан буурсан.



Өнгөрсөн онд зургаан тонн болж, дээрхээс дөрөв дахин буурчээ. Алтны зах зээлийн үнэ өсөөд байхад олборлосон алтны хэмжээ буурч байгаа гол шалтгаан нь хууль эрх зүйн тогтворгүй орчинтой холбоотой хэмээн Монголын алт үйлдвэрлэгчдийн холбоо үзэж байна.

ХӨДӨӨ АЖ АХУЙ



“Хөдөө аж ахуй, мал аж ахуйн маркетингийн төсөл”- ийг Үйлдвэр, хөдөө аж ахуйн яам хэрэгжүүлэх гэж байна. Дэлхийн банкны Итгэлцлийн сангийн 11 сая ам.долларын бүцалтгүй тусламжийн хөрөнгө оруулалттай төсөл юм. Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Хөвсгөл аймгийн 15 сумын иргэд үүнд хамарч буй. Энэхүү төслийн зорилго нь




мал аж ахуйд суурилсан бүтээгдэхүүн үйлдвэрлэлд хөрөнгө оруулалт хийх. Мөн бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх. Зах зээлд нийлүүлэх чадварыг өсгөх замаар хөдөөгийн хүн амын амьжиргаа, хүнсний аюулгүй байдлыг хангахад чиглэж буй.

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ:

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль ирэх оноос хэрэгжиж эхэлнэ. Энэ хуулиудаар зохицуулагдах шинэ томоохон харилцааны нэг нь кастодианы үйлчилгээ. Уг үйл ажиллагааны нарийвчилсан харилцааг зохицуулах журмын төслийг Санхүүгийн зохицуулах хорооноос боловсруулжээ.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт сая ам.доллараар(эхний есөн сарын байдлаар)



ДЭЛХИЙ ДАХИНД:

АНУ



АНУ-д энэ сарын 2-нд “кибр өдөр” зохиогджээ. Онлайн худалдаа 2.29 тэрбум ам.долларт хүрсэн байна. Энэ нь хамгийн их гүйлгээтэй гар утасны боруулалтаас ч давсан үзүүлэлт болов. “Adobe Digital Index” судалгаагаар гар утасны борлуулалт өнгөрсөн оноос 80 хувиар нэмэгдэж, нийт худалдан авалтын дүн 16 хувиар өсчээ. Дэлхийд тэргүүлэгч сүлжээ дэлгүүр болох “Walmart”-ын цахим хуудаст нэг өдөрт нэг тэрбум хүн зочилсон байна.

ЕВРО БҮС



Евро бүсийн аж үйлдвэрийн захиалгын хэмжээ өнгөрсөн сард өсчээ. Энэ нь таван сар дараалан өссөн үзүүлэлт аж. Мөн сүүлийн хоёр жилийн хамгийн хурдацтай өсөлтөд тооцогдож буй. Еврог мөнгөн тэмдэгтээр хэрэглэдэг 17 орноос Франц ганцаараа үйлдвэрийн гарц болон захиалгын хэмжээ нь буурсан үзүүлэлттэй явна. Өнгөрсөн сард евро бүсийн “Худалдан авалтын менежерийн индекс” 51.6 оноотой байв.

БНХАУ

БНХАУ-ын Ерөнхийлөгч Си Жинпинь эдийн засгийн өнөөгийн бодлогоо цаашид үргэлжлүүлнэ хэмээн энэ сарын 3-нд мэдэгдэв. Бодлогын хүрээнд эдийн засгийг цаашид алгуурхан өсгөх, мөн ирэх онд бүх салбарыг хамарсан реформ хийх зэрэг арга хэмжээ багтаж буй. Тэрбээр уг реформ нь нийгэм, эдийн засгийн бүх салбарыг хамарсан, нэгдсэн байдлаар хийгдэнэ хэмээн мэдэгджээ.

ОХУ

ОХУ-ын Засгийн газар алдагдалтай ажиллаж буй уул уурхайн компаниуддаа төрийн батлан даалт гаргахаар болов. Тус улсын Ерөнхий сайд Дмитрий Медведев салбар яамдыг энэ сарын 23-нд төлөвлөгөөгөө гаргаж өгөхийг үүрэгджээ. Үүний зорилго нь дэлхийн эдийн засгийн хямралаас болж алдагдал хүлээж буй компаниуддаа дэмжлэг үзүүлэх. Батлан даалт 2015 оныг дуустал үргэлжилнэ. Мөн тус компаниуд улсын болон бүс нутгийн төсвөөс татаас хүртэхээр болжээ.


ЯПОН

Японы Засгийн газраас төлөвлөөд буй эдийн засгаа дэмжих багц хөтөлбөрийн үнийн дүн 53 тэрбум ам.доллар аж. Ирэх оны дөрөвдүгээр



сард борлуулалтын ашгаас авах албан татварыг таван хувиас найман хувь болгон нэмэгдүүлэх юм. Үүнтэй холбоотойгоор эрэлт, хэрэгцээ буурахаас урьдчилан сэргийлж байгаа нь энэ аж. Багц хөтөлбөрт шинэлэг эмийн үйлдвэрлэл хөгжүүлэх, жижиг компаниудын үйл ажиллагааг гадаадад тэлэх зэрэг багтаж буй. Уг арга хэмжээг хэрэгжүүлснээр тус улс олон улсад өрсөлдөх чадвараа сайжруулах зорилготой аж.

А.Амарсайханы булан



БИЗНЕСИЙН ОРЧИН

ШИНЭЧЛЭЛИЙН САЛХИ

И.ОТГОНЖАРГАЛ

МҮХАҮТ-аас гаргадаг “Бизнесийн итгэлийн индекс-2013” судалгаанд оролцогчдын 47 хувь нь бизнесийн орчинд дунд гэсэн үнэлгээ тавьсан бол 20 хувь муу, зургаан хувь нь маш муу гэжээ. Судалгаанд хамрагдагсадын 73 хувь нь Монголд бизнес эрхлэх орчин хангалтгүй буюу сайн бүрдэж чадаагүй гэсэн дүгнэлт өгчээ. Гэхдээ энэ бол 2013 оны эхний хагаст гарсан судалгаа гэдгийг тэмдэглэх нь зөв байх. Сүүлийн хагаст Хөрөнгө оруулалтын хууль баталж гаргасан, Татварын багц хуулийн шинэчлэлт хийгдэхээр яригдаж байгаа, Засгийн газар, УИХ-ын бизнесийн орчны шинэчлэлийн Ажлын хэсгүүдийн ажил эрчимжсэн, Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж “Том төрөөс ухаалаг төр рүү” гэсэн үндэсний хурлын үеэр “Өнөөдрийн дарлагдсан ард бол бизнес эрхлэгчид байна” гэж хэлсэн гээд бизнесийн орчны шинэчлэлд түлхэц болох олон үзэгдэл үйл явц богино хугацаанд өрнөж буйг дурдах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, оны эхэн хагас өнгөртөл уруу царайлсан гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад сүүлийн хэдхэн сарын дотор итгэлийн оч бадарч байгаа гэсэн үг. Нөгөө талаас өнгөрсөн нэг жилийн хугацаанд бизнесийн орчин, хөрөнгө оруулалтад нөлөөлсөн хүчин зүйл мундахгүй байсан. Тухайлбал, уул уурхайн томоохон төслүүд зогсонги байдалд орж гадаадын хөрөнгө оруулалт 40 гаруй хувиар буурсан, экспортын орлого багассан, төсвийн зардал болоод гадаад худалдааны алдагдал нэмэгдсэн, дэлхийн эдийн засгийн орчин таагүй байсан зэрэг нь Монголын бизнесийн орчин муудахад нөлөөлсөн байх талтай.

Үе үеийн Засгийн газар бизнесийн орчинг сайжруулах, шинэтгэх чиглэлээр ажилладаг. Гэхдээ бодит үр дүн багатай дөрвөн жилийг өнгөрөөх нь бий. Тэгвэл бизнесийн орчины талаар олон зүйл сөхөлгүйгээр одоогийн Засгийн газар юу хийж чадах юм бэ, нөхцөл байдал өнөөдөр ямар байна вэ гэдгийг голлон анхааръя.

“Монголд дотоодын хөрөнгө оруулалтын тухай тусгайлсан хууль тогтоомж ч байхгүй. Гэтэл гадаадын хөрөнгө оруулалтыг хамгаалах төрөл бүрийн дэмжлэг байдаг хэрнээ дотоодын бизнес эрхлэгчдийг зүгээр л зөнд нь хаячихсан. Эцсийн бүлэгт Монголд муу ч сайн ч дотоодын үйлдвэрлэл эрхлэгчид л үлдэнэ” хэмээн бизнес эрхлэгчид гомдоллох нь байсан. Тэгвэл өнгөрсөн арваннэгдүгээр сарын 1-нээс мөрдөгдөгдөж буй Хөрөнгө оруулалтын тухай хуулиар дотоод, гадаад гэж ялгахгүйгээр бизнесийн орчныг бүрдүүлж, дэмжих болсон нь сайшаалтай хэрэг.

Н.Алтанхуягийн Засгийн газар бизнесийн орчны шинэчлэлийг бодитой хийе гэсэн хүсэл эрмэлзэл дүүрэн байгаа нь ялангуяа сүүлийн үеийн баялаг бүтээгчидтэй хийсэн уулзалтаас тодорхой харагдаж байгаа юм.

Дэлхийн банкнаас жил бүр гаргадаг “Бизнес эрхлэхүй” судалгааг хүсэн хүлээдэг, түүнээс улсынхаа бизнесийн орчныг хэрхэн шинэчлэгдэж вэ гэдгийг харах гэж яардаг улс олон. Дэлхийн 185 эдийн засгийг харуулдаг уг судалгаагаар бизнесийн орчныг 10 үзүүлэлтээр судалж гаргадаг. Тэгвэл “Бизнес эрхлэхүй-2014”-ээс Шинэчлэлийн Засгийн газар нэлээд үр дүн хүлээж байсан нь мэдээж. Монгол уг уралдаанд хэр давхисан бэ гэдгийг зарим баримтаар сонирхуулъя.

Монгол Улс Дэлхийн банкны бизнес эрхлэлтийн индексээр 2013 онд 76 дугаар байрт орсон нь өмнөх жилийнхээс 10 байраар ахисан үзүүлэлт юм. Гэвч өрсөлдөх чадварын индексээр 107 дугаар байрт буюу 14 байраар ухарсан байх жишээтэй. Хэдийгээр төр засгаас бизнесийн орчинг сайжруулах чиглэлд анхаарч буй ч үр дүн төдийлэн гарахгүй байгаа нь эндээс харагдаж байна. Уг нь Засгийн газрын шинэчлэл хариуцсан сайд Ч.Сайханбилэгийн ярьж буйгаар шинэчлэлийн Засгийн газар гарч ирэнгүүтээ дээрх “Бизнес эрхлэхүй”-н 10 үзүүлэлтийн тавыг нь барьж авч, ажиллажээ. Үүнд барилгын зөвшөөрөл, цахилгааны холболт, гадаад худалдаа, хөрөнгийн бүртгэл, татвар төлөлт багтаж буй. Эдгээр чиглэлээр багагүй ажил хийсэн байна. Тийм ч учраас манай улс Бизнес эхлүүлэхэд дэлхийн 185 орноос 25-д, Хөрөнгийн бүртгэлээр 27-д, Хөрөнгө оруулагчийг хамгаалах тал дээр 22 дугаар байранд яваа нь чамлахааргүй амжилт юм. Гэвч хийсэн ажилтайгаа харьцуулахад чамлалттай, баттай хэдэн байр урагшилна гэсэн хүлээлттэй байсан зарим салбарын шинэчлэлээр урагшлах биш бүр ухарсан ч тал байна. Тэгвэл юун дээр алдаа гаргав. Тухайлбал, Гадаад худалдаа эрхлэхэд Монголд өмнө нь экспорт импорт тус бүр дээр 10-11 бичиг баримт бүрдүүлэхийг шаарддаг байсан. Засгийн газар энэ тал дээр дээр нэлээд идэвхтэй ажиллаад, Гаалийн тухай хуулиа шинэчлэн найруулж, 10-11 байсан бичиг баримтыг 2-4 болгож цөөлсөн байна. Энгийн бараа бүтээгдэхүүний импорт, экспортод хоёр, харин эрүүл ахуй хорио цээрийн хяналт тавигддаг хүнс, эмийн бараа бүтээгдэхүүнд бол дөрвөн бичиг баримт бүрдүүлж байхаар болж. Засгийн газрын зүгээс за ёстой нэг амжилттай ажиллалаа энэ үзүүлэлтээр ч нэлээд байр урагшлах байх даа гэсэн шүү юм бодож суутал “Бизнес эрхлэхүй-2014”-д 181 дүгээр байр дээрээ хэвээрээ үлдчихэж. Яасан бэ гэхээр “Бизнес эрхлэхүй”-н багийнхан Монголд ирээд



Шог зургийг А.Амарсайхан

бизнес эрхлэгчидтэй уулзаж судалгаа авахад Засгийн газрын хийсэн шинэчлэл бизнесийн талбарт буюу бодит амьдрал дээр мэдрэгдээгүй байсан гэсэн үг. Энэ талаар Ч.Сайханбилэг хэлэхдээ “Өөрчлөлт амар байдаггүй юм байна. Ганцхан хууль батлаад өөрчлөлт бий болдоггүй гэдгийг амссан. Гааль, мэргэжлийн хяналтынхан шинэчлэлийг амар хүлээж авдаг улс биш байна. Тэд шинэчлэгдсэн 2-4 бичиг баримт дотор нөгөө шаардлагагүй гэж үзсэн 5-10 бичиг баримтыг шингээгээд оруулчихсан байсан. Манай бизнес эрхлэгчид ч гэсэн “Хуулиар энэ чинь хүчин төгөлдөр болсон би үүнийг чинь гаргаж өгөхгүй” гэж хэлж чаддаггүй юм байна. Эсвэл тэд шинэчлэлийг мэддэггүй байж ч болох. Тийм болохоор энэ жилийн бидний хамгийн чухал анхаарах асуудал энэ” гэв.

Дараагийн бас нэг хийсэн зүйлтэй хэлэх үгтэй сууж, байр урагшлах бат итгэлтэй байсан хэрнээ өөдлөөгүй салбар нь нь татвар төлөлт. Хувийн хэвшлийнхэн аж ахуйн нэгж эрхлэгчдийн хамгийн дарамттай, толгойны өвчин болсон энэ асуудлаар нэлээд зүйлийг хийж байгаа аж. Асуудлын гол нь монголчууд татварын тайлангаа сар бүр гаргадагт байгаа юм. Үүнийг эхний ээлжинд улирал руу, эсвэл хагас жил рүү оруулах өөрчлөлтийн хуулийн төсөл Сангийн яаманд бэлэн болсон гэнэ. Ингэснээр татварын тайланг жилд нэгээс хоёр удаа л гаргадаг болох юм. Одоо манайх энэ үзүүлэлтээр “Бизнес эрхлэхүй” судалгаанд 74 дүгээр байрт яваа. За энэ ч яах вэ. Хамгийн гол реформ нь энэ онд татвар төлөлт цахим системд шилжсэн явдал. Гэтэл татварын бүртгэлийг цахим хэлбэрт шилжиж явдал суудлаа хөнгөвчлөх гэсэн биш, бид монгол зангаараа “Найдвартай нь дээрээ давхар бичгээр авна” гэдэг бичигдээгүй хууль мөрдөж бүр их чирэгдэл үүсгэх болжээ. Энэ шалтгааны улмаас манай улсын татвар дээр хийсэн шинэчлэлийг Дэлхийн банкны бизнесийн баг тоогоогүй байна. Өөрөөр хэлбэл, тэд “Цаасаа алга болгосон тохиолдолд танай энэ “мундаг” өөрчлөлтийг хүлээн зөвшөөрье” гэсэн аж. За тэгээд дээр дурдсан бусад үзүүлэлтээрээ байр ахисан дэвшсэн тал бий. Тухайлбал, барилгын зөвшөөрөл авах ажиллагаанд мэдэгдэхүйц дэвшил гарсныг монголчуудын олонх нь хэлж буй. Хуучин энэ төрлийн бизнес эрхлэхэд 121 гарын үсэг цуглуулж, 208 өдөр зарцуулдаг байсан бол дөрвөн шатлал руу оруулж, 35 гарын үсэг цуглуулж, нэг цонхоор үйлчилдэг болсон байна. Засгийн газар бизнесийн шинэчлэлээ эрчимжүүлэхээр бизнес эрхлэгчидтэй тулж ажиллаж, байгаа нь тун олзуурхууштай хэрэг юм.

Мөн “Транспаренс интернэйншл” олон улсын байгууллагаас гаргадаг авлигын индексээр Монгол Улс өнгөрсөн оныхоос 11 байраар урагшилж дэлхийд 83 дугаарт бичигдэх болсон сайхан мэдээ ч бий. Гэхдээ авлига, хүнд суртал нийгэмд тэр дундаа бизнесийн орчинд амь бөхтэй оршисоор байгаа нь тулгамдсан асуудал болоод байгаа талаар ам дамжсан яриа ч бишгүй хөврөхийн сацуу гадаад, дотоодын олон байгууллагын судалгаагаар тогтоогдсоор байна. Үүнээс гадна бизнесийн орчин сайнгүй байх олон шалтгааны дотор онцгойлж хэлэх нэг зүйл нь сүүлийн үед төр бизнес эрхэлж, хувийн хэвшилтэй өрсөлдөх байдал гаарч байгаа явдал юм. Уг нь бол төр бизнесийнхэнтэй өрсөлддөг биш, урамшуулдаг, орчин нөхцөлийг нь бүрдүүлэх зохицуулалтыг л хийх үүрэгтэй. Энэ чиглэлээр сүүлийн үед ихээхэн хүчтэй яригдаж байгаа учраас төр нэгийг бодож, хоёрыг тунгаана байх гэж найдъя. Ямартай ч төрийн эрх мэдэлтнүүдийн хатуу чих зөөлөрч, баялаг бүтээгчдийнхээ үгийг сонсдог, сонсоод өнгөрдөг хуучин туршлагаар биш, хийж байгаа ажилдаа тусгаж хэрэгжүүлэхийг оролдож байгаа зүтгэлийг нь бизнес эрхлэгчид озуурхаж байна. Тэд баялаг бүтээж, олон хүний амьдралыг авч явж, улсын хөгжлийг нуруундаа үүрдэг болохоороо ч тэр үү, зөөлөрч уярахдаа амархан хүмүүс ажгуу. Хамгийн гол нь тэдний сэтгэлд энэ Засгийн газар бизнесийн орчны шинэчлэлээр нэг юм хийж магадгүй байна гэсэн итгэлийн оч саяхнаас бадарчээ. Шинэчлэлийн салхи хэдийнэ үлээж эхэлсэн. Эхлүүлсэн шинэчлэлийнхээ эцсийг харуулах хариуцлага ч Засгийн газарт ногдлоо. ■

ЯРИЛЦЛАГА

“ДУНДААС ДЭЭШ ТҮВШНИЙ ХУРДТАЙ ШИНЭЧЛЭЛ”

Б.ТОГТОХ

УИХ-ын гишүүн, МҮХАҮТ-ын тэргүүн С.Дэмбэрэлтэй бизнесийн орчны талаар ярилцлаа.



-Өмнөх Засгийн газрын үед бизнесийн орчны шинэтгэлийн жил зарлаж байсан. Шинэчлэлийн Засгийн газар ч бизнесийн орчныг сайжруулахаар ханцуй шамлан орсон. Хуучин, шинэ шинэчлэлийн ялгаа юу вэ?

-Өнгөрсөн жилүүдэд бизнесийн орчныг шинэтгэх хөрс тодорхой түвшинд бүрдсэн. 2010 онд Засгийн газар бизнесийн орчны шинэтгэлийн жил гэж зарлаад томоохон ажлыг эхлүүлсэн. Тухайлбал, тусгай зөвшөөрөл, гарын үсгийн тоог цөөлөх. Мөн хүнд суртлыг багасгах. Цаашилбал авлигыг бууруулах зэрэг санаачилга гаргаад ажилласан. Үүнээс тодорхой үр дүн гарч, барилгын зөвшөөрөл хүссэн гарын үсгийн тоо гэхэд багассан байдаг. Гэхдээ нэг зүйлийг орхигдуулж байсан. Энэ нь хүнд суртал юм. Хэдий нэг гараараа шинэчлэл хийсэн ч нөгөө гараас нь хүнд суртал ургаад байсан. Үүнийг олж хараагүй. Өмнөх шинэчлэлээс үлдсэн хамгийн том “өв” бол хүнд суртал юм. Үүнтэй шинэчлэлийн Засгийн газар тэмцэх ёстой.

-Та бизнесийн орчинд хамгийн том садаа болж буй зүйл бол хүнд суртал гэж хэллээ. Тэгвэл одоогийн Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлогын үр дүнд энэ байдал өөрчлөгдөж, бизнесийн орчин сайжрах дүр зураг харагдаж байна уу?

-Хүнд суртал шарилжтай адил. Тиймээс Засгийн газар хүнд суртлаас аль болох зайлсхийх хэрэгтэй. Түүнтэй нөхөрлөж болохгүй. Дэлхийн банк болон Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын гаргасан судалгаанд үндэслэж , түүний дагуу Засгийн газар шинэчлэл хийх нь зөв. Гэхдээ бусад хүчин зүйлд анхаарч, түүнд ач холбогдол өгөх учиртай. Ингэснээр шинэчлэл илүү далайцтай болно. Гол нь урьд өмнө үгүй болсон хүнд суртал, тусгай зөвшөөрөл, лиценз эргээд дахиж төрөхгүй байх ёстой. Энэ бүхэн дахин шарилж мэт ургахгүй байх нөхцөлийг Засгийн газар бүрдүүлж өгөх хэрэгтэй. Нөгөө талаасаа шинэчлэлд оролцооны арга их чухал байдаг. Өмнөх болон түүний өмнөх Засгийн газарт оролцоо тун бага байсан. Дараагийн Засгийн газар оролцоог хангалттай оруулж өгсөн. Тэгвэл энэ Засгийн газар ерөнхийдөө оролцоонд түшиглэж шинэчлэл хийж байна. Өөрөөр хэлбэл, хэт их дүрэм, журам, хүнд суртлаа өртөж байгаа хэсгийн төлөөллийн дуу хоолойд үндэслэж, төр хувийн хэвшлийн түншлэлийн зарчмаар шинэчлэлийг хэрэгжүүлж байна. Дүгнээд хэлэхэд шинэчлэлийн Засгийн газрын реформ хандлага нь эрс гэдгээрээ ялгарч байгаа. Тиймээс бодитой үр дүн гарна гэж харж байна.

-Таныхаар бодитой үр дүн гарах

үндэслэл болоод итгэл төрүүлж байгаа зүйл нь юу вэ?

-Дээр би “эрс” гэж онцолж хэлсэн. Бизнесийн орчныг сайжруулахын тулд эрс шинэчлэл хийх ёстой. Ингэснээр олон жилийн турш ярьж, мөрөөдөж буй орчин сайжрах юм. Сүүлийн үед “Гуллотин онол” гэж бий болсон. Энэ нь XVI зууны үед хүнийг цаазлахдаа тусгай бэлдсэн цаазын тавцан дээр гаргаад толгойг нь том сүхээр цавчдаг. Энэ нь эрс цавчих, үндсээр нь цавчих гэсэн тийм утгатай. Орчин үед реформын арга барил болж хувирсан. Үүнийг Gullotine approach хандлага буюу арга барил гэж нэрлэдэг. Энэ нь олон улсын хэмжээнд Jacobs Associates гэсэн хууль эрх зүйн компанийн барааны тэмдэг нь болоод явж байх жишээтэй. Маш олон оронд энэ аргыг хэрэглэж байна. Монгол Улс ч гэсэн одоо эрс шинэчлэлийн арга барилаар ажиллаж байна. Өөрөөр хэлбэл, эрс өөрчлөх. Хүнд суртлыг үндсээр нь авч хаях. Ингэснээр бизнесийн орчин тунгалагших юм. Засгийн газрын тогтоолоор Хэрэг эрхлэх газрын дарга Сайханбилэг сайдын ахалсан ажлын хэсэг эрс өөрчлөлт хийхээр ажиллаж байна. Үүнд нь бизнес эрхлэгчид оролцоод санал бодлоо илэрийлээд явж байгаа. Энэ талаас нь авч үзэх юм бол реформ зөв эхэлж байна. Энэ байдал нь бизнесийн орчинд эрс шинэчлэл хийх найдвар төрүүлж байгаа юм.

-Хэт олон дүрэм журам, зөвшөөрөл газар дээрээ бодитой цөөрч байна уу?

-Тусгай зөвшөөрөл, лиценз гэхэд 1100 орчим байна. Үүнийг аажим аажмаар цөөрүүлэх ёстой. Мэдээж өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн бодлогын явцад олон гарын үсэг, бичиг цаас бүрдүүлэх ажил харьцангуй багассан. Барилгын зөвшөөрөл өмнөх Засгийн газрын үед 143 байсан бол одоо 60 болсон. Гэхдээ үүнийг барилгын салбарт ажиллаж буй компаниуд их байна гэж үзэж байгаа. Тиймээс цаашдаа буурна байх.

-Засгийн газрын эрс шинэчлэл хийх багийг дэмжих Дээд комисс байгуулсан дуулдсан. Энэ нь юу хийх вэ?

-Саяхан Ерөнхий сайдын захирамжаар УИХ-ын таван гишүүнээс бүрдсэн эрс шинэчлэл хийх реформын багийг дэмжих Дээд комисс гэж байгуулагдсан. Үүнд миний бие болон Гарамгайбаатар, Батчимэг, мөн Дэмбэрэл гишүүнийг томилсон байгаа. Комиссыг Сайханбилэг сайд ахална.

Хэрэг эрхлэх газрын Хууль зүйн асуудал эрхэлсэн даргын ахалсан ажлын хэсэг гэж бас байгуулагдсан. Тус ажлын хэсэг бүх яамдын гаргаж буй тусгай зөвшөөрөл, лицензийг шүүж үзээд шийдэж чадахгүй байгаа асуудлаа УИХ-ын гишүүдээс бүрдсэн Дээд комисст оруулж, тэнд асуудлыг эцэслэн шийднэ. Асуудлыг шийдэх арга энгийн. Тухайн яамны удирдлагаас энэ тусгай зөвшөөрөл яагаад хэрэгтэй талаар тайлбар авна. Мэдээж хэрэг ийм учраас гээд нэг хариулт хэлэх байх. Тэгвэл энэ тусгай зөвшөөрөл чинь тухайн салбарын чөлөөт, шударга өрсөлдөөнд саад болж байна уу. Мөн хүнд суртлыг агуулсан уу. Уг тусгай зөвшөөрлийг бусад мэргэжлийн төрийн бус байгууллага, холбоонд яагаад шилжүүлж болохгүй байгаа юм гэсэн тодорхой хэдэн асуултын хүрээнд хариулах ёстой. Эдгээр асуултад оновчтой хариулж, хамгаалж чадаж байвал тусгай зөвшөөрөл үлдэнэ. Чадахгүй бол “цаазална” гэсэн үг.

-Өнөөдрийн бизнесийн орчинг та хэрхэн дүгнэх вэ. Үнэхээр хүнд, ээдрээтэй орчин мөн үү?

-Монголын нийт компани өнөөдөр санхүүгийн тааламжтай бус орчинд амьдарч байгаа. Өөрөөр хэлбэл, тэд ганцхан сонголттой нүүр тулдаг. Энэ нь зээлийн өндөр хүүтэй, богино хугацаатай орчин. Үүнд тааруулж, бизнесээ явуулж байна. Бизнесийн орчны реформын нэг хэсэг нь санхүүгийн орчны асуудал байгаа. Хэдийгээр Засгийн газраас жижиг, дунд үйлдвэрлэлийг тодорхой хэмжээнд дэмжиж, арга хэмжээ авч байгаа ч үүний үр дүн нийт бизнесийн орчинг хамарч чадахгүй байна. Тиймээс бизнесийн орчны бүрдэл хэсэг болох санхүүгийн орчныг өөр бодлогоор зохицуулах нь оновчтой. Энэ нь мөнгөний болон сангийн бодлого. Мөнгөний бодлогын ажлын хэсгийг ахалсан хүний хувьд хэлэхэд 2014 оных өмнөх 20 жилийн мөнгөний бодлогоос зарчмын хувьд өөр болсон. Өөрөөр хэлбэл, бичил, дунд бизнесийн санхүүгийн орчныг бий болгох чиглэлээр Засгийн газар, Монголбанк ажиллах юм .

-Ирэх оны мөнгөний бодлогын үр дүнд ямар асуудлыг голчлон шийдэхээр байгаа вэ?

-Валютын ханшийн эрсдэлээс хамгаалах үндэсний хэмжээний механизмыг бий болгох чиглэлд бодитой ажил хийж эхэлнэ. Мөн санхүүгийн салбарын өнөөгийн хандлага болох 96х4 буюу банкууд 96, үлдсэн санхүүгийн салбарын дөрөв гэсэн харьцааг аль болох зохистой болгох эхлэлийг тавих юм. Ингэснээр зээлийн хүү буурах орчныг мөнгөний бодлогоор дамжуулан бүрдүүлнэ гэсэн үг. Өргөн утгаар нь аваад үзэх юм бол санхүүгийн салбарт шинэчлэл хийнэ. Дунд хугацааны бичиг баримтыг батлах гэх мэт санхүүгийн салбарын реформ явгдаж эхэлж байна. Хажуугаар нь бизнесийн салбарын зөвхөн тусгай зөвшөөрөл, лиценз биш бизнес эхлэхээс дуусах хүртэлх цикльд нь төрийн зүгээс хэт их оролцохгүй байх. Төр өөрийнхөө тодорхой чиг үүргийг зоригтойгоор хувийн хэвшилд шилжүүлэх алхмуудыг хийх. Үүнд өнөөдрийн Монголын бизнесийн орчны реформын ерөнхий утга санаа нь оршиж байгаа юм.

-Бизнесийн орчныг шинэтгэх ажил хэр хурдтай явж байна вэ?

-Засгийн газрын зүгээс хурдацтай болгох талаас нь анхаарч ажиллаж байгаа. Ямар ч гэсэн энэ онд бизнесийн орчинг сайжруулах гэсэн оролдлогыг төр хийгээд эхэллээ. Энэ хугацаанд барилга, эрчим хүчний тусгай зөвшөөрөл. Мөн компани үйл ажиллагаа эхлэх зэрэг тодорхой бичиг баримтад өөрчлөлт гарлаа. Цаашдаа энэ хурдаа сайжруулах тал дээр ажиллах шаардлага байгаа. Тэр тусмаа ирэх он бол энэ чиглэлд голлон анхаарах жил гэж харж байна.

Хамгийн гол нь аливаа реформын үр дүнг тухайн реформ хийгдэж байгаа салбарын бизнес эрхлэгчид амьдралд биеэрээ мэдэрсэн үед л шинэчлэл сайн явж байна гэж хэлнэ. Энэ онд хийж буй реформ одоогоор бүхэлд нь биш ч гэсэн нэлээд хэсэгт нь мэдрэгдээд байна. Тийм учраас сая Ерөнхий сайд бизнес эрхлэгчидтэй “Баялаг бүтээгчдийн уулзалт”-ыг зохион байгуулаа. Тус уулзалтаа

тодорхой салбаруудад хуваагаад дуу хоолойг нь сонслоо. Зөвхөн дуу хоолойг сонсоод зогсохгүй газар дээр нь асуудлыг шийдэх маягаар асуудалд нэлээд шинэлэг болоод сорго хандаж байна. Тиймээс реформын хурд дундаас дээш түвшинд байна гэж хэлье. Үүнийг улам түргэсгэх шаардлагатай. Би өмнө нь хэлсэн. Бизнесийн орчны шинэчлэл маань хоёр зорилттой. Нэг нь хүнд суртал мэтийн муу зүйлүүдийн өнгөн хэсгийг тайрах бус үндсээр нь ургахгүй байх тэр нөхцөлийг нь бүрдүүлэх. Реформд хурд, дараалал хоёрыг иж бүрэн тооцох хэрэгтэй.

-“Баялаг бүтээгчдийн уулзалт”-аар бизнес эрхлэгчид бодлогын түвшинд шинэчлэл гарч байгаа ч хэрэгжүүлэх шатанд шинэчлэлийн үр дүн гарахгүй байгааг хэлж байсан. Тухайн шинэчлэлийг хэрэгжүүлэх, түүнийг нэвтрүүлэх талын ажилд манай төрийн байгууллага нэлээд хойш сууж хандаад байх шиг. Та үүнтэй санал нийлэх үү?

-Улс оронд хэрэгжиж байгаа бизнесийн орчны шинэтгэлийн хамгийн гол садаа бологч хүчин зүйлийн нэг нь наад асуудал чинь байгаа юм. Аливаа реформыг маш сайн бодож, дээрээс нь доошоо. Доороос нь дээшээ гэсэн хоёр хандлага уулзаж байхаар зохион байгуулахгүй бол дунд болон доод шатны засаглалын түвшинд болон дундаас доош засаглалын түвшинд чимээгүй эсэргүүцэл их байдаг. Үл мэдэхийн эсэргүүцэл гэж хэлж болно. Бүр хүсэхгүй байх эсэргүүцэл чимээгүй явж байдаг. Энэ нь реформыг удаашруулах, түүний хүчийг сааруулах. Хийх ажилд саад учруулах. Мөн хийхгүй гэсэн байдлаар шалтаг тоочих, хойш тавих байдлаар хандах нь бий. Үүнийг бүх реформ хийж байгаа сайд болон хамтраад ажиллаж буй төрийн бус байгууллага сайн анзаарч байх ёстой. Ингэхийн тулд хөндлөнгийн мониторинг хийх. Ажлын явцтай байнга танилцах учиртай. Тухайн шинэчлэлийн бодлого зорилтот түвшинд хэрхэн хүрсэн. Ажил амьдрал дээр хэрхэн хэрэгжиж байгааг шалгаж байж шинэчлэл бодит ажил болно.

-Таны зүгээс бизнесийн орчны шинэчлэлд юуг анхааруулж хэлэх вэ?

-Тухайн реформыг хариуцаж байгаа сайд нар итгэл үнэмшилтэй хандах ёстой. Шинэчлэлийн явцад нэг дутагдал ажиглагдаж байгаа. Шинэчлэл бол Сайханбилэгийнх биш. Ерөнхий сайд Алтанхуягийн реформ ч биш. Энэ бол шинэчлэлийн гэх тодотголтой Засгийн газрын бүх сайдын асуудал. Тиймээс сайд нар үүнд тэгш бас сэтгэлтэй. Мөн итгэл үнэмшилтэйгээр оролцох учиртай. Өөрөөр хэлбэл, шинэчлэлийг Н.Алтанхуяг, Ч.Сайханбилэгийн асуудал гэж ойлгох хандлага яваад байх шиг байна. Тийм учраас чимээгүй эсэргүүцэл дээр ч илэрч магадгүй. Манай яаманд энэ лицензүнэхээр хэрэгтэй гээд хэрэггүй асуудал оруулаад ирж магадгүй. Тиймээс өмнө нь хэлсэн эрс шинэчлэлийн реформын арга чухал. Үүний ташуурыг сая Ерөнхийлөгч өгчихлөө. Том байна. Ухаалаг болцгооё гэж. Ухаалаг гэдэг чинь мэдээллийн технологийг ашиглаад оршин байгаа хүнд суртлыг тэр чигээр нь автоматжуулна гэсэн үг биш. Тэр байгаа хүнд суртлыг мэдээллийн технологи байхгүй юм шиг хийж, хялбаршуулж, цөөрүүлэх. Үүн дээрээ мэдээллийн технологийг туслах чанартай оруулж өгөх юм. Ингэснээр төрийн үйлчилгээ ухаалаг төр лүү шилжих ийм нөхцөл бүрдүүлэхийг том төрөөс ухаалаг төр лүү шилжих гэж нэрлээд байгаа юм.

> Реформ дооройсоо дээшээ нэвт явах ёстой. Тухайн реформыг хариуцаж байгаа сайд нар итгэл үнэмшилтэй хандах ёстой. Шинэчлэлийн явцад нэг дутагдал ажиглагдаж байгаа. Шинэчлэл бол Сайханбилэгийнх биш. Ерөнхий сайд Алтанхуягийн реформ ч биш. Энэ бол шинэчлэлийн гэх тодотголтой Засгийн газрын бүх сайдын асуудал. Тиймээс сайд нар үүнд тэгш бас сэтгэлтэй. Мөн итгэл үнэмшилтэйгээр оролцох учиртай.

-Бизнесийн орчны талаар Дэлхийн банк болон танай танхимын судалгаа гарсан. Тус судалгаанаас үзэхэд бизнес эрхлэгчдэд төрийн бодлогын дэмжлэг тэгш бус байгааг онцолсон байна лээ. Та энэ талаар юу хэлэх вэ?

-Бизнес эрхлэгчдийн судалгаа мухардалд орсон хариултыг өгдөг. Энэ нь “төр ядахдаа, битгий саад болооч” гэж. Нэг талаасаа бизнесийн орчинд төр хэт оролцож байгааг ийн хэлж байгаа юм. Мэдээж бизнесийн талбарт ажиллаж буй хүмүүст бүхэлдээ төрийн бодлогын дэмжлэг хэрэгтэй байгаа. Бодлогын дэмжлэгт нь сангийн болон мөнгөний бодлогын дэмжлэг орж байгаа юм. Тийм учраас би өмнө хэлсэн. Мөнгөний бодлого анх удаа бичил, дунд бизнесийн санхүүжилтийг сайжруулах. Мөн ээлийн хүүг дунд хугацаанд бууруулах орчныг бүрдүүлэх. Санхүүгийн салбарын реформыг ирэх оноос эхэлж дунд хугацаанд буюу 2016 он хүртэл хийхээр болсон. Өнөөдөр Засгийн газар тодорхой нэг салбарыг дэмжих нь зүйтэй. Жишээлбэл, Үнэ тогтворжуулах хөтөлбөр байна. Гэхдээ бүхэлдээ нийт бизнесийн идэвхжилтийг нэмэхийн тулд бизнесийн таатай орчинг бүрдүүлэх хэрэгтэй. Энэ нь санхүүгийн тааламжтай орчинг бүрдүүлнэ гэсэн үг. Бүхэлдээ гэдэгт жижиг, дунд бизнес, үйлчилгээний бизнес эрхлэгч, экспортлогч багтаж байгаа. Заавал ноос ноолуур байх албагүй. Өөр зүйл бид экспортолж болно. Тухайлбал, аялал жуулчлалын чиглэлээр. Мөн органик бүтээгдэхүүн. Төрөл бүрийн үнэ тогтворжуулах хөтөлбөр ороогүй салбарт нийтээрээ тэгш, шударга өрсөлдөх. Бизнес хийхийг нь дэмжсэн төрийн бодлогыг өнөөдөр бизнесийн салбарынхан шаардаад байгаа юм. Тиймээс ирэх оны гол зорилт бол энэ. ■



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

АЛГА ТАШИЛТЫН АРД

Э.ЗОРИГТ

Монголын хөрөнгө оруулалтын орчин тогтворгүй, тодорхойгүй бараг хоёр жил болов. Үүний эцэст шинэхэн мэндэлсэн Хөрөнгө оруулалтын тухай хуулийг тойрсон өөр өөр байр суурь бий. Эдийн засагт гарах эерэг үр дүнгийн талаарх хүлээлт, хөрөнгө оруулагчдын итгэл сэргэсэн болов уу гэх таамаг ч үргэлжилсээр. Өнгөрсөн сарын 18-20-нд Хонконгт болсон “Mongolia Investment Summit 2013” арга хэмжээ өнгөрсөн жилийг бодвол халуун дулаан уур амьсгалтай, эерэг сэтгэгдэл ихтэй байсан талаар тус чуулганд оролцогч албаны болон хувийн хэвшлийн төлөөлөгчид санал нэгтэй, өндөр сэтгэгдэлтэй өгүүлж байна. Гурав дахь удаагаа болж буй тус чуулганд 18 улсын 320 орчим төлөөлөл оролцжээ. Энэ нь Монголыг шохоорхох гаднын хөрөнгө оруулагчдын итгэл дахин сэргэсэн гэдгийн баталгаа юм. Өнгөрсөн жилийн Хонконгийн хөрөнгө оруулалтын хурлаас манай төлөөлөгчид нэлээд уруу царайлж ирсэн. Цаг цагаараа байдаггүй ээ гэж. Усны шувууд шиг орхиод одсон тэдний заримыг ямар аясын салхи нь Монгол руу эргүүлсэн юм бол. ЭЗХЯ-ны Хөрөнгө оруулалтын газрын дарга С.Жавхланбаатар “Энэ онд баталсан Хөрөнгө оруулалтын хуулиар суурь эрх зүйн зохицуулалтаа хийж чадлаа. Тус хуулиар Монголын зах зээлийг нээлттэй, бүх талын хөрөнгө оруулагчдад ээлтэй болгож чадсан. Мөн Хөрөнгө оруулалтын үр шимийг хэрхэн зохицуулах вэ гэдгийг тодорхой болгосон. Тиймээс хөрөнгө оруулагчдын итгэл дахин сэргэсэн гэж хэлж болно” гэв. Энд эхлээд хуулийн давуу талыг дурдъя. Хуулийн гол үзэл баримтлал нь хөрөнгө оруулагчдыг гадаад, дотоодын гэж алагчлалгүй бүх хөрөнгө оруулагчид 5-22 жилийн дараа ч өнөөдрийнхөө хуулиар зохицуулагддаг тийм тогтвортой байдлыг бий болгосон гэдэгт олзуурхах хүн олон. Мөн өөр нэг давуу тал нь хувийн хөрөнгө оруулагчид Засгийн газраас зөвшөөрөл авахгүйгээр стратегийн гэж нэрлэгддэг уул уурхайн болон бусад салбарт хөрөнгө оруулах боломж нээгдэж байгаа явдал юм. Гэхдээ хуулийн 21.1-т . . . “Дараах салбарт үйл ажиллагаа эрхлэх Монгол Улсын хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 33 буюу түүнээс дээш хувийг гадаадын төрийн өмчит хуулийн этгээд эзэмших тохиолдолд зөвшөөрөл авна

-21.1.1.уул уурхай;

-21.1.2.банк, санхүү;

Тогтворжуулах гэрчилгээ олгох хугацаа /жилээр/

Хөрөнгө оруулалтын хэмцээ /тэрбум төгрөгөөр/	Улаанбаатарын бүс	Төвийн бүс Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Дархан-Уул, Өмнөговь, Сэлэнгэ, Төв	Хангайн бүс Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл	Зүүн бүс Дорнод, Сүхбаатар, Хэнтий	Баруун бүс Баян-Өлгий, Говь,Алтай, Завхан, Увс, Ховд	Тогтворжуулах гэрчилгээ олгох хугацаа /жилээр/	Хөрөнгө оруулалтаа хийж дуусах хугацаа /жилээр
30-100	5	6	6	7	8	8	2
100-300	8	9	9	10	11	11	3
300-500	10	11	11	12	13	13	4

-21.1.3.хэвлэл, мэдээлэл, харилцаа холбоо" гэж заасан байна. Энэ нь зах зээлээ хамгаалсан бодлого гэдгийг УИХ-ын гишүүд тайлбарлаж байсан. Түүнчлэн гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг татахын тулд төслийн үр ашигт тулгуурлан зарим татварыг тогтворжуулах тогтолцоог бий болгосон. Энэ бас хуулийн нэг давуу тал. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 14.1-т заасаар... "Тогтворжуулах гэрчилгээгээр албан татвар, төлбөрийн хувь, хэмжээг гэрчилгээ хүчинтэй байх хугацаанд тогтворжуулна.

Эдгээрээс гадна энэ хуульд өөрчлөлт оруулах асуудлыг Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүй саналаар шийдвэрлэнэ гэж тусгажээ. Энэ нь гаргасан хуулиа байн байн өөрчилж, "сюрприз" барьдаг УИХ-ын гишүүдийн тогтворгүй занг аргамжих арга төдийгүй Хөрөнгө оруулалтын тухай хуулийн амин сүнс гэж олзуурхаж болох. Энэ мэт хуулийн ололттой заалтуудыг дотоод, гадаадын хөрөнгө оруулагчид алга ташин угтаж авсан. Гэхдээ алга ташилтын ард...

Хөрөнгө оруулагчдад айх юм үлдсэн үү?

Үлдсэн гэж хэлбэл та гайхаж магадгүй. Шинэ хууль мэндэлсний маргаашнаас л талууд Хөрөнгө оруулалтын тухай хуулийн талаарх өөр өөрийн байр сууриа илэрхийлж эхэлсэн. Гэхдээ олонхийн хүлээн зөвшөөрч байгаагаар шинэ хуулиар хийж чадаагүй нэг зүйл байна. Тэр нь хуулиар тогтворжуулсан дөрвөн төрлийн татвараас гадна өөр төрлийн татвар нэмэгдэхээр бол Тогтворжуулах гэрчилгээтэй компанид нөлөөлөхгүй гэх. УИХ гишүүн Д.Оюунхорол "Хөрөнгө оруулагчдын хувьд тогтвортой орчныг л хүсдэг. Гэтэл тэр тогтвортой байдлыг нь бий болгох Тогтворжуулалтын гэрчилгээтэй хөрөнгө оруулагчдад гэнэт гарч ирэх аливаа татварын нэмэгдэл нөлөөлөхгүй гэх заалтаа яагаад хасчихсан юм бол" гэж хэвлэл мэдээллээр мэдэгджээ. Хууль санаачлах дуртай гишүүд маань Гэнэтийн ашгийн 68 хувийн татвар шиг шинэ татварын тухай хууль, заалт санаачлаад олонх нь гар өргөөд баталчихвал юу болох вэ. Тэр үед Монголын төр нэг гараараа баталсан хуулиа нөгөө гараараа баллах хар түүхийг дахиад л эхлүүлж магадгүй.

Хүлээлт

Гадаадын хөрөнгө оруулалт 40 гаруй хувиар уруудсан дүнтэй байгаа гэж Монголын гадаад худалдаа, эдийн засгийн хөгжлийг дэмжих төвөөс гаргасан судалгаанд дурдсан байна. Энэ байдлаараа гаднын хөрөнгө төдийлэн нэмэгдэхгүй байсаар 2013 оныг үдэх нь. Харин монголчууд хүлээсээр. Монгол Улсад 2014-2018 онд уул уурхайн олборлох хийгээд боловсруулах, дэд бүтцийн хөгжлөө дэмжих болон бусад салбарт хөрөнгө оруулахад 84 орчим тэрбум ам.доллар шаардлагатай аж. Энэ талаар "Mongolia Investment Summit 2013" чуулганы үеэр дурдагджээ. Ийм их мөнгө Монголын төр, түмэн олон татвар төлөгчид, бизнесмэнүүдийн алинд ч байхгүй. Тиймээс гаднын хөрөнгө оруулалт зайлшгүй хэрэгтэй. Тэр тусмаа улсын зээлийн хэмжээг ДНБ-ий 40 хувиас хэтрүүлэхгүй гээд тогтоочихсон. Олон улсын зах зээлээс нэмж бонд босгох "эрхээ хасуулсан" манай оронд гаднын хөрөнгө оруулагчдыг хүлээхээс өөр зам үлдсэнгүй бололтой.

Хүлээхэд учир бий

Унжаад байхаар унаад ирээсэй гээд үлгэрийн төгсгөл шиг хүлээлт бидэнд хэрэггүй. Тиймээс шинэ хууль баталчихаад хөрөнгө оруулагчид хүрээд ирээсэй гээд хүлээгээд суух нь утгагүй. Усны шувууд шиг зантай хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээхийн тулд шийдвэрлэх ёстой ажил Засгийн газарт олон байгаа аж. "Новатерра" ХХК-ийн захирал Б.Бямбасайхан "Mongolia Investment Summit 2013" чуулганы үеэр Монголд хэрэгжиж байгаа дөрвөн том төсөл болох "Оюутолгой", "Тавантолгой", ТЭЦ-5 болон "Тавантолгой"-н төмөр замын талаар хөрөнгө оруулагчид их сонирхож байлаа. Учир нь хөрөнгө оруулагчид Монголд хөрөнгө оруулах итгэлийг дахин олж авахын тулд өнөөдөр хэрэгжиж байгаа төсөл чинь хэр амжилттай явж байна гэдэгт анхаарлаа хандуулж байна" гэсэн юм.

Гэтэл эдгээр нь маш том төслүүд. Том учраас олон жил хэрэгжих учиртай. Гэвч зарим төслийг тухайлбал, ТЭЦ-5-ын талаар үе үеийн Засгийн газар яриад байгаа болохоос ажил хэрэг болгосон нь үгүй. Үүний цаана байгаа ужиг хүнд өвчин бол нөгөө л төрийн залгамж халаатай холбоотой. Төрийн ярьсан санаачилсан томоохон төслүүд сонгууль дамжин сунжирдаг, сонгуулийн дараа "унждагт" хөрөнгө оруулагчид бас л дургүй. Тиймээс хууль баталснаас гадна хийх ёстой ажил, эмчлүүлэх хэрэгтэй салбар байгаа гэдгийг онцлох хүн олон байна.

СУДАЛГАА

БИЗНЕСИЙНХНИЙ ИТГЭЛ ХЭР БАЙНА ВЭ

МҮХАҮТ-аас эрхлэн гаргадаг “Бизнесийн итгэлийн индекс-2013” судалгааны товч дүгнэлтийг хүргэж байна. Тус судалгааны зорилго нь бизнесийн салбарт авч хэрэгжүүлж буй төрийн бодлого, шийдвэр бодит ажил хэрэг болж байгаа эсэх. Мөн бизнес эрхлэгчдийн үйл ажиллагаанд ямар нөлөө үзүүлж байгаа. Цаашдаа хэрхэн өөрчлөгдөх хүлээлтийг эндээс харж болох юм.

Дэлхийн эдийн засаг бүрэн сэргээгүй. Манай улсын экспортын гол нэр төрлийн бүтээгдэхүүний түүхий эдийн үнэ унаж байгаа. Түүнчлэн гаднын хөрөнгө оруулалт зогсонги байдалд орсон, валютын ханшийн огцом өсөлт, ажилгүйдэл улам бүр өсөн нэмэгдэж байгаа зэрэг нь төр засгаас илүү ухаалаг бодлого явуулах шаардлагатай байгааг сануулсаар. Нөгөөтэйгүүр эдийн засаг, бизнесийн салбарын өсөлт, хөгжлийг эрчимжүүлэх. Амжилтаа хадгалж үлдэх эсэх нь төрийн бодлогоос ихээхэн шалтгаалахыг судалгаанд онцолжээ.

Тус судалгаанд Улаанбаатар болон хөдөө, орон нутгийн 2500 гаруй бизнес эрхлэгчийг хамруулжээ. Нийт оролцогчдын 74 хувь нь бизнесийн байгууллагад, 11 хувь нь төрийн албан хаагч. Үлдсэн нь мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагад ажилладаг байна.

Судалгаагаар дээр дурдсанаас гадна макро эдийн засгийн үндсэн асуудлууд болох ядуурал, ажилгүйдэл, инфляци, хөрөнгө оруулалтын орчин зэргийн талаарх бизнесийнхний байр суурь, хүлээлт ямар байгааг тодруулах. Мөн бизнесийн орчныг сайжруулах чиглэлд нэн тэргүүнд хэрэгжүүлвэл зохих асуудлуудаар судалгаанд оролцогчдын санал бодлыг гаргахыг зорьжээ. Бид энэхүү өргөн хүрээтэй судалгаанаас бизнест саад болж байгаа нь юу байна, цаашид хэрхэх ёстой вэ гэдэг санааг нь товчлон хүргэж байна.

Бизнес эрхлэхэд хамгийн их саад болж буй хүчин зүйлд судалгаанд оролцогчдын 46,8 хувь нь бизнес дэх төрийн оролцоо, зохицуулалт хэмээн хариулсан байна. Сүүлийн жилд төрийн зүгээс бизнес хийх сонирхол улам бүр өсөн нэмэгдэж төрийн өмчит олон компани, үйлдвэрийн газруудыг байгуулж зах зээлд нэвтрэх болсон. Тиймээс хувийн хэвшил, тухайн салбарын бизнесийнхэн шахагдаж үйл ажиллагаа нь хумигдаж эхэлсэн нь энэхүү хариултыг өгөхөд хүргэсэн байна.



Нийт судалгаанд оролцогчдын 41,6 хувь бизнест саад болж буй хүчин зүйлсийн нэг томоохон нь төрийн байгууллагуудын хүнд суртал гэж үзжээ.

Засгийн газрын зүгээс бизнест шаарддаг зөвшөөрөл лицензийг багасгах чиглэл баримталж буй. Гэсэн ч энэ нь маш удаан, хэрэгждэггүй зэргээс хамааран бизнес эрхлэхэд ихээхэн саад тушаа болдог гэжээ. Бизнест саад болж буй дараагийн тулгамдсан асуудал нь авлига, хээл хахууль хэмээн судалгаанд оролцогчдын 35.8 хувь дүгнэсэн байна. /Хүснэгт-1-ээс харна уу/

Хүснэгт 1. Бизнесийн орчны өөрчлөлтийн талаарх судалгаанд оролцогчдын үнэлгээ

2010	2011	2012	2013	Өөрчлөлт	
				2012	2013
Эрс сайжирсан	7,9%	4,1%	8,3%	3,8%	- 4,5 %
Бага зэрэг сайжирсан	61,5%	27,4%	30,5%	34,6%	+4,1 %
Огт өөрчлөгдөөгүй	15,3%	13,8%	14,7%	17,3%	+2,6 %
Бага зэрэг муудсан	0	36,7%	33,1%	18,4%	-14,7 %
Маш их муудсан	0	11,6%	2,3%	16,2%	+13,9
Хариулж мэдэхгүй	15,3%	6,4%	11,1%	9,7%	-1,4 %

Судалгаанд оролцогчдын бизнесийн орчны өөрчлөлтөд өгсөн хариултаас үзэхэд өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад муудах тал руу хандсан гэж 35.6 хувь нь үзжээ. 9.7 хувь нь хэлж мэдэхгүй, 17.3 хувь нь бизнесийн орчинд ямар ч ахиц дэвшил гараагүй гэсэн байна.

Судалгаанд оролцогчдын өгсөн хариултыг өмнөх онтой харьцуулж үзэхэд Монголын бизнес, санхүүгийн орчин бага зэрэг сайжирсан гэх үнэлгээ энэ онд 4.1 хувиар өсжээ. 2012 оны хагас жилийн байдлаар эдийн засаг, бизнесийн орчин ялимгүй муудсан гэсэн санал 33.1 хувийг эзэлж байсан бол энэ оны байдлаар 18.4 хувь болж 14.7 хувиар буурчээ. Харин анхаарах нэг зүйл бол бизнесийн орчин маш их муудсан гэсэн үзэлтэй хүмүүсийн тоо өмнөх оныхоос 13.9 хувиар өссөн байна. /Хүснэгт-2-оос харна уу/.

Хүснэгтэд судалгаанд хамрагдсан хүмүүс ажил эрхлэлтийн байдлаас хамааран ямар үнэлэлт дүгнэлт өгч байгааг харууллаа. Тухайлбал төрийн байгууллагад ажиллагсадын 89,5 хувь нь бизнесийн орчин өмнөх жилийнхээс сайжирсан гэжээ. Харин хувийн хэвшилд ажиллагсдын 34,6 хувь нь сайжирсан гэсэн хариулт өгсөн нь ихээхэн зөрөөтэй байна. Олон улсын байгууллагад ажиллагсдын хувьд Монголын бизнес, санхүүгийн орчин нөхцөл маш их муудсан гэсэн бол ТББ, бусад салбарт ажиллагсдын хувьд ерөнхийдөө бизнесийн орчин муудсан гэсэн хандлага давамгайлж байна.

Гэвч судалгаанд хамрагдсан 10 хүн тутмын зөвхөн гурав нь бизнесийн орчин сайжирсан гэж үзсэн нь анхаарал татаж байна.

Дүгнэлт:

Ялангуяа төрийн хүнд суртал, авлига хээл хахууль, бодлого шийдвэрийн тогтворгүй байдал зэрэг нь бизнес эрхлэхэд хамгийн их саад тээг болж байгааг бизнесийнхэн, судлалгаанд оролцогчид онцлон тэмдэглэж байна. Түүнчлэн банк санхүүгийн орчин ч сайнгүй байгааг шүүмжилжээ. Ирэх жилд бизнесийн орчин сайжирна гэсэн найдлага, хүлээлт ч муу байна. Хөрөнгө оруулалт сайжирч бизнесийн үйл ажиллагааг идэвхижинэ гэсэн хүлээлт ч хангалтгүй байна.

Ядуурал, ажилгүйдэл, инфляци зэрэг нийт иргэд, бизнесийнхэнтэй шууд холбоотой асуудлуудын талаар ч судалгаанд оролцогчдын хувьд өөдрөг хүлээлт, итгэл багатай байна. Нэг үгээр хэлэхэд Монгол Улсад бизнес эрхлэхэд учрах саад бэрхшээл, дарамт шахалт их байна. Үүнийг олон жил ярьсан, хэлсэн, гэвч олигтой үр дүн гарахгүй байгааг эцэслэх цаг болсон гэж үзжээ.

Судалгааны үр дүнтэй холбоотойгоор бодлого боловсруулагчдын хувьд нэн тэргүүнд авч үзэх, хэрэгжүүлэх, ажил хэрэг болгох шаардлагатай зарим санал, зөвлөмжийг нэгтгэн үзүүлснийг хүргэе.

Зөвлөмж:

-Төр бизнес эрхлэх таатай орчинг бүрдүүлэх. Ингэснээр улс орны эдийн засаг, бизнесийн хөгжил эрчимжиж, үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлд шинэ алхам болно. Энэ нь бизнес эрхлэгчдэд шинэ итгэлийг өгөх юм.

-Төрийн зохицуулалт, бизнес дэх төрийн оролцоог багасгах. Өнөөдөр төртэй өрсөлдөхүйц хэмжээний том бизнесийнхэн манайд бараг байхгүй. Төр хувийн хэвшилтэй өрсөлдөх нь зах зээлээс шахагдахад хүргэж байна.

-Хэт олон зөвшөөрөл лицензийг багасгана гэсэн амлалтаа хэрэгжүүлэх. Одоогийн 1200 гаруй зөвшөөрөл лицензийг наад зах нь 50 хувь багасгах. Цаашилбал, боломжит доод хэмжээнд хүртэл цөөлөх.

-Хүнд суртал, авлига төрийн байгууллагад амь бөхтэй оршсоор. Уг байдал нь улам бүр даамжирч байгааг зогсоох.

-Мөнгө сангийн бодлогоор бодит секторыг дэмжсэн, нэн ялангуяа бичил жижиг бизнесийг дэмжих чиглэлд хэрэгжүүлэх.

-Банк санхүүгийн салбарт шударга өрсөлдөөн өрнүүлэх. Санхүүжилтийн шинэ эх үүсвэрийг нэвтрүүлэх чиглэлд дорвитой өөрчлөлт хийх.

-Бодлого, шийдвэр, төр засгийн үйл ажиллагаа тогтвортой байхыг иргэд, бизнесийнхэн хүсч байна.

-Валютын ханшийг тогтворжуулж валютын эрсдэлээс хамгаалах үр ашигтай механизм нэвтрүүлэх, эдийн засгийг хэт долларжихаас сэргийлэх

-Үндэсний манлай аж ахуйн нэгжүүдээ дэмжсэн, тэдний үйлдвэрлэл үйлчилгээг өргөжүүлэх тусгай хөтөлбөр, төсөл боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай. Аль ч улсын хувьд үндэсний томоохон аж ахуйн нэгжүүддээ тулгуурлан өсч өндийдөг жамтайг сануулж байна. ■

Хүснэгт 2. Бизнесийн орчны өөрчлөлтийн талаарх үнэлгээ, судалгаанд оролцогчдын ангиллаар

	Төрийн байгууллага	ОУБ	ТББ	Хувийн хэвшил	Бусад	Хувь
Эрс сайжирсан	31.6%	.0%	.0%	0.8%	.0%	3,8%
Бага зэрэг сайжирсан	57.9%	.0%	36.8%	33.8%	20.0%	34.6%
Огт өөрчлөгдөөгүй	10.5%	.0%	15.8%	20.8%	.0%	17,3%
Бага зэрэг муудсан	0%	.0%	42.1%	17.7%	.0%	18.4%
Маш их муудсан	0%	100.0%	5.3%	16.2%	40.0%	16,2%
Хариулж мэдэхгүй	0%	.0%	.0%	10.8%	40.0%	9.7%
Нийт хувь	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%

АМЖИЛТЫН ТҮҮХ

ӨЧИГДӨР, МАРГААШИЙН ҮЛГЭРИЙН ЕРТӨНЦ:

УОЛТ ДИСНЕЙ



Б.БЯМБАДОРЖ

Хүүхэд байхад Уолт Дисней гэдэг үгс нь миний дуртай хүүхэлдэйн киноны эхлэлийн нэгэн дохио л байсан. Харин Дисней гэж жинхэнэ хүн байснаар барахгүй дэлхийн хүүхэлдэйн киноны салбарыг бүхэлд нь өөрчилсөн. Мөн тус салбарыг өнөөдрийн зэрэгт хүргэсэн гавъяатай.

Түүний дуу, өнгө хослуулсан шинэлэг хүүхэлдэйн кинонууд нь ирээдүйн маш олон хүүхэлдэйн кино бүтээгчид урам зориг өгч, цаашид хөгжих замыг нь засч өгсөн. Тэрбээр XX зууны эхэн үеэр хүүхэлдэйн киноны шинэ түүхэн хуудас нээсэн билээ. Бизнес эрхлэх сайн чадвараа бүтээлч сэтгэлгээтэйгээ зөв хослуулан ашиглаж чадсан нь энэ ололт юм.

Мэдээж Уолт Диснейд энэхүү чадварууд эхээс заяагаагүй. Харин амьдралынхаа турш хөдөлмөрлөсний үр дүн юм. Залуу Уолт энэхүү чадваруудаа өдөр бүр хурцалж, маш олон алдаа, азгүйтэл, дампуурлыг даван туулжээ. Эцэст нь дэлхийд хүүхэлдэйн шинэхэн ертөнц бэлэглэж чадсан.

Өнөөдөр дэлхийд Оскарын шагнал хамгийн олон хүртсэн хүн Уолт Дисней. Тэрбээр Оскарын шагналд 59 удаа нэр дэвшиж, 22 удаагийн шагналын эзэн болсон. Мөн хүндэтгэлийн Оскарыг дөрвөнтөө хүртжээ.

Алдаа, оноо

Уолтер Элиас Дисней 1901 оны арванхоёрдугаар сарын 5 –нд АНУ –ын Чикаго хотод мэндэлжээ. Түүний эцэг Элиас Дисней төмөр замын барилгын ажил эрхэлдэг байсан учир тэднийх байнга шахуу нүүдэг байв.

Тэрбээр Миссури мужийн Марселин хотод амьдарч байхдаа хөршийнхөө Руперт хэмээх морийг тодорхой урамшуулал цалинтайгаар зурдаг байв. Түүний зураг зурах авьяас, сонирхол ингэж илэрчээ. Үүндээ хөтлөгдөн сурагч болоод сургуулийн сониндоо зураачаар ажиллаж. Дэлхийн I дайны үе байсан учир түүний зургийн сэдэв нь ихэвчлэн дайны ухуулга, сурталчилгаа байж. Удалгүй Уолт сургуулиас гарч, дайнд оролцохоор шийджээ. Гэвч 16 настай буюу насанд хүрээгүй учир цэрэгт авах боломжгүй гэдгийг албаны хүмүүс хэлж гэнэ.

Хэдий тийм ч Уолт ямар нэг байдлаар дайнд мордох сэтгэлдээ хөтлөгджээ. Нэгэн найзтайгаа Улаанзагалмай нийгэмлэгт элсэж, Франц улсад жилийн турш шархадсан цэргүүдийг зөөдөг эмнэлгийн машины жолоочоор ажилласан байна.

Буцаж ирээд дүү Ройгийн тусламжтайгаар Уолтер “Рубин Арт” хэмээх студид ажилд орж зар сурталчилгааны зураг зурдаг болов. Энд ажиллаж байхдаа Уолт ирээдүйн найз, бизнесийн хамтрагч болох Аб Айверкстэй танилцжээ. Хоёр залуу “Рубин Арт” –аас гараад хувийн зар сурталчилгааны компани байгуулав. Тус компани нь хэдхэн сарын дараа санхүүгийн шалтгаанаас болж дампуурчээ. Уолт Канзас хотын бас нэгэн зар сурталчилгааны байгууллагад ажилд орсон аж. Харин энэ удаа Уолт хүүхэлдэйн кино хийж байв. Хүүхэлдэйн киноны урлагийг энд ажиллаж байхдаа нэлээд сонирхож, улмаар хүүхэлдэйн кино бүтээгч болохоор шиджээ.

Удалгүй Уолт дахиад л хувийн бизнес эхлэхээр сэтгэл шулуудаж Чикаго хотын томоохон театрын эзэн Фрэнк Л.Ньюмантай хүүхэлдэйн киногоо театрт нь гаргах тохиролцоонд хүрчээ. Түүний шинэ хүүхэлдэйн киноны нэр нь “Newman Laugh-O-Grams” байсан ба хотынхоо хүрээнд богино хугацаанд алдаршиж чаджээ. Гэвч энэ бизнес нь бага орлоготой байсан.

Ажилчдынхаа цалинг тавьж дийлэхгүй дампуурч, Уолт багагүй хэмжээний өрөнд унажээ.

Иймд ах дүү Уолт, Рой хоёр мөнгөө нийлүүлэв. Тухайн үеийн, мөн өнөөдрийн АНУ–ын кино урлагийн төв болох Калифорни мужийн Холливүүдийг зорилоо.

Энэ үед Уолт Дисней 21 настай байсан юм.

Зах зээлээ ойлгосон нь: Микки Маус

Уолт Холливүүдэд ирээд жилийн дотор “Дисней студи” –ийг байгуулж, дистрибьютэрээр “Universal Pictures” –тэй гэрээ хийж амжив. Студид элссэн ажилтнуудын нэг нь Уолтын найз Аб Айверкс байжээ.

Энэ үед Уолт олон нийтэд таалагдах ямар нэг хүүхэлдэйн дүр хэрэгтэйг мэдсэн юм. Иймд “Oswald the Lucky Rabbit” хэмээх туулайн дүр бүтээж хэд хэдэн хүүхэлдэйн кино хийж, АНУ –д танигдах болов. Харамсалтай нь студийн зардал орлогоосоо даваад ирсэн байна. Тэрбээр “Universal Pictures” –ийн төв рүү явж бүтээж буй хүүхэлдэйн кино бүрийн нэгж үнийг нэмэхээр зэхэж гэнэ. Харин ч өөдөөс нь нэгж үнийг бууруулах санал тавьсан нь Уолтыг гайхшруулж орхив. “Oswald” туулайн албан ёсны эрхтэй “эзэн нь” Уолт биш “Universal Pictures” байж. Тэд Уолтод товчхондоо “Үнийн саналыг зөвшөөрөхгүй ч гэсэн бид чамтай, чамгүй энэ хүүхэлдэйн дүрийг цааш нь аваад явна” гэж хэлсэн гэнэ.

Иймд Уолт аргагүйн эрхэнд бүтээсэн дүрээ орхин дахиад л хоосон хоцров.

Түүний дараагийн бүтээсэн хүүхэлдэйн дүр нь Микки Маус байсан юм. Хулганы гадаад төрхийг Аб Айверкс зурж Уолт өөрөө дууг нь оруулж байв. “Микки Маусын Алтан Үе” номонд Дисней студийн нэгэн зураач “Аб Миккигийн биеийг зурсан, харин Уолт түүний сүнс, сүлдийг өгсөн” гэж хэлсэн байдаг. Анх Уолт шинэ хулганадаа Мортимер гэж нэр өгчээ. Гэтэл түүний эхнэр Лилиан энэ нэр нь олон нийтийн сонирхлыг татахгүй гэж хэлээд, Миккийг санал болгосон нь ийнхүү алдаршжээ. Мортимер хулгана дараа нь Микки Маус хүүхэлдэйн киноны нэгэн “дайсан” болсон юм.



Микки Маусын олон нийтэд хүрсэн анхны богино хэмжээний хүүхэлдэйн киноны анги нь “Steamboat Willie” нэрээр гарчээ. Энэ хүүхэлдэйн кино нь түүхэндээ дуу, дүрс хоёр нь зөв хосолсон хамгийн анхных гэдгээрээ онцлог юм. Үүнээс хойш тухайн үеийн бүх хүүхэлдэйн кино “Steamboat Willie” –ийн дуу оруулах аргыг загварлажээ. Хэд хэдэн Миккитэй хүүхэлдэйн кино гаргасны дүнд Микки Маус, Чарли Чаплинтай хамт дэлхийн хамгийн алдартай, олны танил дүрүүд болсон байна.

Микки Маусын дараах Уолтын бүтээл нь “Silly Symphonies” буюу “Хөгжилтэй аялгуу” хэмээх богино хэмжээний хүүхэлдэйн киноны цуврал байсан юм. Энд бас нэгэн шинэ зүйл нь АНУ –д шинээр нээсэн Technicolor хэмээх технологийг зөв ашигласан өнгөт хүүхэлдэйн кинонууд байж. Энэхүү 1930 –аад оны цувралуудад шинэ дүр олон байсан. Олон нийтэд хамгийн алдаршсан нь Доналд нугас байжээ.

“Silly Symphonies” алдрын оргилд богино хугацаанд хүрч, цувралуудын агуулга, өндөр түвшний дүрслэл, урьд өмнө нь хар-цагаан кинонд ч байгаагүй хошигнол зэргийг АНУ –ын Урлагийн Академи үнэлэв. Тиймээс долоон цуврал нь Оскарын шагнал хүртээжээ. Хүүхэлдэйн киноны түүхэнд энэ амжилттай дүйцэж шагнал авсан ганц цуврал нь “Tom & Jerry” байсан юм. (1940 – 1950 –иад оны “Metro-Goldwyn-Mayer” студийн бүтээл).

“Silly Symphonies” цувралуудаас санаа авч, тухайн үеийн хүүхэлдэйн киноны бизнест хөл тавих зорилгоор “Warner Bros” студи мөн л “Looney Tunes” хэмээх богино хэмжээний хүүхэлдэйн цувралууд гаргаж, “Bugs Bunny”, “Duffy Duck” хоёр дүрийг бүтээжээ. “Looney Tunes” нь “Silly Symphonies” нэртэй адил хөгжилтэй аялгуу гэсэн үг юм.

Уолтын “Микки Маус,” “Хөгжилтэй аялгуу” цувралуудын бас нэг онцлог нь 1930 –аад оны эдийн засгийн уналт ба Дэлхийн II дайны үед амьдарч байсан хүмүүсийн аж байдлыг маш хөгжилтэйгөөр дүрсэлж байсан явдал юм. Тухайлбал, Оскарын шагнал хүртсэн “Хөгжилтэй аялгуу” цувралын “The Three Little Pigs” ангийн дуу нь 1933 онд АНУ –ын эдийн засгийн уналтын “сүлд дуу” болж байжээ.

Энэ үе нь Уолтын хувьд дүрс үзүүлэх болон өгүүлэх олон арга хэлбэрийг “туршсан” чухал үе байсан. Тэр нь түүний дараагийн ажил болох “Цасангоо ба долоон одой” –д маш чухал үүрэг гүйцэтгэсэн юм.

Дэлхийн анхны өнгөтэй, дуутай бүрэн хэмжээний хүүхэлдэйн кино


1934 онд Уолт өнгө, дуу хосолсон бүрэн хэмжээний кино төлөвлөж эхлэв. Тэр үед ийм хэмжээний хөрөнгө, мөнгө шаардсөн ажил хийсэн студи байгаагүй. Энэ эрсдэлтэй үйлдэл нь “Дисней” студийг уналтад оруулна гэж олон хүн бодож байв. Түүний дүү Рой, эхнэр

Лилиан хоёр нь энэ ажлыг болиулах гэж ятгасан ч дийлсэнгүй. 1934 оны сүүлээр Ах дүү Гриммийн зохиолоос сэдэвлэсэн “Цасангоо ба Долоон одой” нэртэй бүрэн хэмжээний хүүхэлдэйн киног “Дисней” студид хийж эхлэв. Энэ үед Уолт зураачдынхаа чадварыг хөгжүүлэх ажил хийж, “Silly Symphonies” цувралууд дээр ажлаа жишээ болгож байв.

Кино бүтээх ажил 1937 он хүртэл үргэлжилжээ. Мөн оны дунд үеэр “Дисней” студийн мөнгө дууссан байна. Уолт бараг дууссан киногоо аваад зээлдүүлэгч байгууллагуудтай тохиролцож, тэдэнд бүтээлээ үзүүллээ. Зээлдүүлэгчдэд Уолтын шинэ кино их таалагдаж, кино төгсөхөд бүгд босоод алга ташиж байв.

Киногоо дуусгахад шаардагдсан мөнгийг амжилттай босгоод удалгүй “Цасангоо ба долоон одой” АНУ –ын нийтийн театруудад гарч эхэллээ.

Олон нийт энэ киног маш өндрөөр үнэлж, бусад кино бүтээгчид, ялангуяа дуугүй киноны “хаан” гэгдэх Чарли Чаплин хүүхэлдэйн кино урлагт Уолтын гаргасан амжилтыг магтаж байв. Өнгө, дуу хослуулсан дэлхийн хамгийн анхны бүрэн хэмжээний хүүхэлдэйн кино байснаараа уг бүтээл нь онцлог. Шүүмжлэгчид Уолтын үйл явдал өгүүлэх чадвар, нарийвчилсан дүрслэл зэргийг сайшааж байжээ. Түүнчлэн “Цасангоо ба долоон одой” нь 1938 онд гарсан ямар ч киноноос дөрөв дахин их орлого олсон юм. Ердийн Америкийн иргэд маргааш нөгөөдрийн хоолоо олж ядах эдийн засгийн уналтын үед ийм их ашиг олсон нь гайхамшигтай хэрэг



билээ.

Уолтын шинэ киног Оскарт нэр дэвшүүлэхэд хүндрэлтэй байсан нь тэр үед бүрэн хэмжээний хүүхэлдэйн кинонд тохирох ангилал, төрөл байгаагүй юм. Иймд Урлагийн Академи Уолт Диснейд 1939 онд хүндэтгэлийн Оскар гардуулжээ.

“Цасангоо ба долоон одой” нь олон янзын бүтээлийн үлгэрлэгч болсон. Тухайлбал, 1939 онд гарсан Дэвид Флетчерийн “Гулливерийн Аялал” Уолтын шинэ кинотой “өрсөлдөх” гэж гарсан юм.

Энэ загварыг ашиглан “Дисней” студи “Pinocchio”, “Fantasia”, “Dumbo”, “Bambi”, “Alice in Wonderland”, “Peter Pan” зэрэг хэд хэдэн хүүхэлдэйн киног ар араас нь маш богино хугацаанд амжилттай гаргажээ.

Үлгэр жишээ хүн

Амжилттай бизнесмэнээс гадна Уолт нь ажилчидтайгаа ойрхон ажилладаг нэгэн байж. Диснейтэй цуг ажиллаж байсан хүмүүс түүнийг их бүтээлч, уран дүрслэлтийн чадвар маш сайтай хүн гэцгээдэг. Түүний студид ажиллаж байсан нэгэн зураач хэлэхдээ “Ер нь бидэнд гурван төрлийн Уолт байсан. Тэдгээр нь мөрөөдөгч, реалист, шүүмжлэгч байсан. Бид хурал дээр яг хэн нь ирэх бол гэж гайхдаг байлаа.” Мөрөөдөгч нь ажилчидтайгаа шинэ мөрөөдлийн ертөнц хуваалцдаг байсан бол реалист нь байгууллагын санхүүгийн байдал, өрсөлдөгчдөө ярьдаг байж. Харин шүүмжлэгч нь хийсэн ажлыг дүгнэж, зөв бурууг нь зааж, үнэлдэг байсан гэнэ. Тэрбээр өөрийн ажлыг гадны нүдээр харах нь хамгийн чухал гэж байнга сануулдаг байжээ.

Уолт Диснейн ажлын зарчим, түүнээс сурах зүйлсийн тухай маш олон академи, судалгааны ажлууд байдаг. Харин Уолт Диснэй өөрөө хэнээс үлгэр жишээ авсан бэ? Тэр хүн нь мэдээж хэрэг Уолт Диснейн залуу насны киноны баатар байсан Чарли Чаплин юм.

Уолт Чарли Чаплинаар “манлайлуулсан” дуугүй киноны алтан үед өсчээ. Чарли Чаплины I, II дайн ба эдийн засгийн уналтын үетэй хослуулсан урлагийн хошигнол нь Уолтын Микки Маусыг бүтээхэд их хувь нэмэр оруулсан юм. Микки Маусын зарим ангид Чарли Чаплины алдартай кинонуудын хэсэг ч гардаг. Уолтын өсвөр насны үед “Чарли Чаплиныг хэн сайн дууриах вэ” тэмцээн АНУ –д их зохиогддог байж. Уолт Чарли Чаплиныг багаасаа үзэж өссөн бөгөөд түүнийг дууриаж жүжиглэх дуртай нэгэн байжээ. Дээрх тэмцээнүүдэд амжилттай оролцож, түүний өөрийн үгээр “хааяа нэг доллар, ихэвчлэн гэртээ харих унааны мөнгөө хождог байсан” гэсэн юм.

Түүний “Дисней” студи дэх амьдралд Чарли Чаплин мөн л нөлөө үзүүлж байж. Уолттай ажиллаж байсан хүмүүс “Уолт бидэнд юу харуулах гээд байгаагаа Чарли Чаплины дүрд орж харуулдаг байсан. Тийм ч болохоор бид түүнийг сайн ойлгож хүүхэлдэйн киноны баатруудын нүүр хувирлыг маш сайн гаргаж чаддаг байсан. Уолт сайн жүжигчин болох байсан даа” гэж хэлжээ.

Бүх зүйлд эхлэл, төгсгөл гэж бий. Уолт Дисней тамхи их татдаг хүн байсан хэдий ч хүүхдүүдийн хажууд хэзээ ч үгүй. 1966 онд хүзүүний гэмтлээсээ болж мэс засал хийлгэх гэж эмч дээр очжээ. Үзлэгийн үеэр уушигны хорт хавдартай гэдэг нь оношлогджээ. Хавдар нь зүүн уушгинд бүхэлд нь тархсан байсан учир уушгиа авахуулсан байна.

Харамсалтай нь Уолт Дисней уушигны хорт хавдраас үүдсэн өвчнөөс болж 1966 оны арванхоёрдугаар сарын 15 –нд өөд болсон юм.

“Дисней” студид ажиллаж байсан хөгжмийн зохиолч Роберт Шерман Уолт Диснейг хамгийн сүүлийн удаа харснаа дурсжээ. “Тэр ‘Happiest Millionaire’ киног хариуцаж байгаа хүмүүстэй гуравдугаар давхарт уулзаж байсан. Ихэвчлэн үүдэнд уулзаж, санал бодлоо солилцоно. Уолт тэдэнтэй энэ кинон дээр таалагдсан, таалагдаагүй зүйлсээ хэлээд, өөрчлөлт оруулах талаар ярьж дуусан бидэн руу томоохон инээмсэглэж хараад, “Ажлаа сайн үргэлжүүлээрээ залуусаа” гэж хэлээд явсан даа. Бид түүнийг сүүлийн удаа харсан нь энэ юм” гэжээ.

Түүний гайхамшигт бүтээл, үлгэрийн ертөнц нь өнөөг хүртэл дэлхийн сая сая хүмүүсийг баясгаж байгаа. Залуу наснаасаа эхэлж уйгагүй хөдөлмөрлөсөн Уолт Дисней хүсэл, зориг байхад дэлхийг өөрчлөх боломжтой гэдгийг амьдралаараа харуулсан гайхалтай нэгэн байсан билээ. ■

АВЛИГА

АВЛИГЫН ЭСРЭГ СОНГОЛТ

Б.АЛТАЙ

Аливаа улсад бизнесийн үйл ажиллагаа хэдий чинээ өргөжин тэлж хөгжинө, тэр хэмжээгээр иргэд нь ажлын байртай, орлоготой. Мөн ажилгүйдэл, гэмт хэрэг зэрэг нийгмийн асуудал бага. Нөгөөтэйгүүр татварын орлого өндөр байж нийтийн боловсрол, эрүүл мэнд, аюулгүй байдал зэрэг нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмж дээшлэх юм. “Төрийн гүйцэтгэх гол үүрэг нь бизнес эрхлэх хамгийн таатай орчныг бүрдүүлж, бизнес дэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх явдал” хэмээн “Монгол Улсын эдийн засгийн эрх чөлөөний тойм”-д дурдсан байдаг. Бизнес амжилттай явах, урт хугацаанд ашиг орлого олох. Мөн өрсөлдөх чадвартай байх үндэс нь юун түрүүнд бизнесийн орчин аж.

Жишээлбэл, орчин үеийн мэдээллийн технологийн зах зээлийг байлдан дагуулж буй Ipod-ыг АНУ-ын Засгийн газраас тусгайлан дэмжсэн учраас гарч ирээгүй нь тодорхой. Ийм бүтээгдэхүүн дэлхийн зах зээл дээр гарч ирж, “Apple” компани болон АНУ-ын нэрийг мандуулна гэж Америкийн улстөрчид зүүдлээ ч үгүй биз. Гагцхүү бизнес эрхлэх еерэг орчинг бүрдүүлж, хувийн санаачлагыг дэмжих. Зарцуулсан хөдөлмөр болон гаргасан санаачлагынхаа үр шимийг чөлөөтэй хүртэх боломжийг олгосон учир зах зээл өөрөө ийм амжилтыг төрүүлж чаддаг байна. Төр “ялагч” нарыг тодруулах биш. Харин зах зээл өөрөө “ялагч” нарыг тодруулах нь эдийн засгийн өсөлтийн суурь нь болж өгөх ёстой.

Манай улсын хувьд бизнесийн орчин төдийлэн таатай бус байгааг тус салбарт ажиллаж, амьдарч буй хүмүүс хэлэх нь бий. “Улс орны хэмжээнд авлига маш их байна. Тухайлбал, зөвхөн Улаанбаатар хотод л гэхэд хүмүүс, албан тушаалтнуудад жилдээ 479 тэрбум төгрөгийн авлига өгдөг гэсэн баримт судалгаа байх жишээтэй. Хотын төсвөөсөө илүү хэмжээний авлига авдаг гээд бод доо” хэмээн Нийслэлийн ИТХ-ын дарга Д.Баттулга хэлсэн юм.

“Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдал” гэсэн судалгааг манай улсад байгаа АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг/ОУХА/-аас хийжээ. Судалгаанд 330 гаруй компани хамрагдсан байна. Компаниудын 86 хувь нь жижиг, дунд. Үлдсэн нь том компани аж. Компаниудыг салбараар нь авч үзвэл, худалдаа, үйлчилгээ, үйлдвэрлэл, уул уурхай, хөдөө аж ахуй, барилга угсралтын компани голлож байна.

Тус судалгаанд “Жижиг, дунд компаниудад авлига нь том компанитай харьцуулахад илүү хүндээр тусч, бизнесийн үйл ажиллагаанд саад болж байна” гэжээ. Мөн сүүлийн жилүүдэд төрийн байгууллага дахь авлига хувийн хэвшилд тархах болсныг тэмдэглэсэн байна. Ингэснээр жижиг, дунд бизнес эрхлэгчидтэй харьцуулахад том бизнес эрхлэгчид өөрсдийн нөөц бололцооныхоо ихэнх хувийг үр ашиггүй, хүнд суртал бүхий үйл ажиллагаанд зарцуулдаг байна. Тэдний 17 хувь нь ажлын цагийнхаа 50-иас дээш хувийг үйлдвэрлэлийн бус саад бэрхшээлийг шийдвэрлэхэд үрдэг. Өөрөөр хэлбэл, авлига, төрийн албаны хүнд суртлаас үүдэн “баялаг бүтээгчид” сул зогсолт хийхэд хүрдэг гэсэн үг.

Харин жижиг компаниудын найман хувь нь бололцооныхоо 25-аас дээш



хувийг үйлдвэрлэлийн бус асуудлыг шийдэхэд зориулдаг аж. Тэр тусмаа барилга угсралтын салбар бизнесийнхэн дундаа хамгийн их шүүмжлэлд өртөг байна. Судалгаанд өгүүлснээр барилгын компаниудын нэр хүнд төдийлэн сайн биш. Гэсэн ч тухайн салбарыг бүхэлд нь авч үзвэл тэдэнд учирдаг ихэнх бэрхшээл дарамт шахалт Засгийн газрын агентлагуудын зүгээс ирдэг аж.

Мөн уул уурхайн салбарт ч ялгаагүй дээрх шинж тэмдэг илэрдэг байна. Уг байдлаас түргэн гарах, асуудлаа шийдүүлэх. Мөн лиценз, зөвшөөрөл, гарын үсгээ авахын тулд авлига өгдөг гэжээ. Нэг үгээр, төрийн алба үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй атлаа далд авлига авч байгаа нь ёс бус гэмт хэрэг юм. Бизнес эрхлэгчид хэзээд өндөр татвар төлөгчид байдаг. Улсын төсвийн орлогын 70 гаруй хувийг бүрдүүлж байдаг. Мөн ажлын байр шинээр бий болгож, улс орны хөгжилд томоохон үүрэг гүйцэтгэдэг “нэргүй албат” юм. Гэвч тэднийг үнэлэх бус мохоох нь их. Зах зээлээс шахах. Төрийн нэрээр дарамтлах байдал газар авсныг Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж “Том төрөөс ухаалаг төр луу” үндэсний зөвлөлдөх уулзалтын үеэр төрд анхааруулсан юм.


Ерөнхийлөгч хэлсэн үгэндээ “Өнөөдрийн дарлагдсан ард бол бизнес эрхлэгчид. Бизнес эрхлэгчдийг дарамталдаг бүхэл бүтэн тогтолцоо байна” гэв. Ерөнхийлөгч төр бизнест оролцдоггүй, хэрэгтэй үед нь тусалдаг, сонирхлын зөрчилгүй байх ёстойг сануулсан. Ийм бизнесийн таатай орчныг тус салбарынхан хүсч байгааг мэдэгдсэн юм. Өнөөдөр бизнес эрхлэгчид эрх зүйн тогтвортой, тэгш, тунгалаг орчин. Мөн өрсөлдөхүйц, зохистой, төлөвлөж болохуйц татварын орчныг мөрөөдсөөр байгааг Ерөнхийлөгч хэлсэн. Нөгөөтэйгүүр ямар ч тохиолдолд төр аж ахуйн нэгж байгуулаад, бизнес эрхлэгчидтэйгээ өрсөлдөх ёсгүйг дээрх уулзалтын үеэр бас дурдсан.

Харин төр болон бизнесийн хоорондох харилцаанд авлига хэрхэн нөлөөлж байгаа талаар ямар нэгэн судалгаа, мэдээлэл өнөөг хүртэл манай улсад хийгдээгүй иржээ. Үүнийг нөхөх гарын авлага гэж хэлж болох дээрх судалгаанаас бизнесийн орчин дахь авлигын өнөөгийн дүр зургийг харж болохоор. Бизнесийн орчинд гэлтгүй Монгол Улсад авлига нэн түрүүнд тулгамдаж буй асуудал гэдэгтэй хэн хүнгүй санал нэгдэх болсон. Түүний үр дагаврыг хүртэгсэд өнөөдөр авлигын “тор”-ноос шилжин “төмөр тор”-ны цаана эрх чөлөөгөө хасуулж буй. Өөрөөр хэлбэл, төр бизнес эрхлэгчдийг заримыг “гэмт хэрэгтэн” болгохын зэрэгцээ бизнест нь “хар тамга” дарсаар байгаа.


Авлига нь аль нэг байгууллага дангаар шийдвэрлэчихдэг асуудал биш. Харин нийгмийн салбар бүрийн хамтарсан хүчин чармайлт шаарддаг болохыг “Бизнес эрхлэлтийн орчин дахь авлигын нөхцөл байдал” судалгаанд тэмдэглэжээ. Төр үйлчилгээ үзүүлж, ажил үүргээ гүйцэтгэх учиртай. Гэтэл үүнийхээ төлөө шан харамж горьдох ёсгүй. Чин үнэнчээр үүргээ хэрэгжүүлсэн бол амжилт хүсээд үлдэх нь зүйд нийцнэ. Гэтэл “хойноос чангаах” нь эрүүл бус хандлага. Энэ байдал нь нийгэмд шударга бус байдлыг гаруулж, түүнд авлига өгч, урамшуулж байгаа нь бизнес эрхлэгчдийн буруу ажиллагаа болохыг мөн дурджээ.

Төрийн албан хаагчдад илүү мөнгө төлөх нь энгийн

Бизнесийн үйл ажиллагаанд хамгийн их саад учруулж байгаа байгууллагууд



Хувийн хэвшлийн салбарт авлига хэр их байна гэж Та боддог вэ?



Авлигад өртөмхий салбарууд /олон сонголттой/



зүйл болж, бизнес эрхлэгчид төрийн албан хаагчдад дэмжлэг үзүүлэх замаар өөрсдөдөө ашигтай шийдвэрийг гаргуулж байна. Энэ байдал эргээд нөгөө талдаа хүлээлтийг бий болгож, улмаар зах зээлийн эдийн засгийг бүхэлд нь гажуудуулах үндэс суурь болдог аж. Өрсөлдөх талбаргүй бол зах зээлийн орц гарц зогсолтод орж, өрсөлдөөн үгүй болох. Эдийн засаг гажуудан хяналтаас гарч, цаашдын хөгжилд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэйг тус судалгаанд тэмдэглэжээ. Тэгвэл судалгаанд хамрагдсан оролцогчдын дөнгөж 12 хувь нь л авлигын эсрэг ямар нэгэн арга хэмжээ авч хэрэгжүүлдэг гэжээ. Үлдэж буй 88 хувь нь нэг талаасаа авлигыг хөхиүлэн дэмжиж байгаа хэрэг юм.

Судалгаанд оролцсон компаниудын 42 хувь нь төрийн байгууллагад авлига их гэж үзжээ. Тэд сүүлийн хагас жилд өөрсдийн үйл ажиллагаа эрхэлж байгаа салбартаа төр болон хувийн компанийн харилцаанд авлигын чанартай зүйл байгааг анзаарсан байна. Ялангуяа барилгын салбарынхан авлигын талаар хамгийн их мэдээлэлтэй байжээ. Бизнесийн үйл ажиллагаанд хамгийн их саад учруулдаг байгууллагаар Татварын алба “тодорсон” байна. Дараа нь Мэргэжлийн хяналтын ерөнхий газар орж байна.

Төрийн байгууллага дахь авлига буурвал бизнес эрхлэгчдийн цэвэр ашиг өснө гэж оролцогчдын 50 хувь үзжээ. Гэтэл 26 хувь нь авлига буурвал ашиг буурна гэжээ. Түүнчлэн зарим оролцогчид ихэвчлэн зөвхөн төрөөс олж авдаг зарим нөөц боломжоо алдахаас эмээж байгаагаа илэрхийлсэн байна. Авлига буурсан тохиолдолд барилга угсралтын салбарт орлого нэмэгдэх аж. Авлига зөвхөн төрийг худалдаж авах хэрэгсэл байхаас гадна өрсөлдөгчөө түлхэн унагах цорын ганц арга зам болсон байгаа нь анхаарал татсан юм. Энэхүү судалгаанд оролцогчдын олонх нь авлига авсан өгсөн аль алинд хариуцлага тооцох ёстой гэж үзсэн байна.

Бизнес эрхлэгчдийн хувьд хэн нэгэн эрх мэдэлтний гарыг хүндрүүлэх. Эсвэл бизнесийн түүхдээ “delete” хийх болдог. Тиймээс авлига өгөөд ч болов оршин тогтнохын тулд гэсэн хандлага нь төр томрох шалтгаан болж, үүнээс үүдэн эдийн засгийн хөгжил саарч байгаа юм. Мөн бизнес эрхлэгчид төрийн буруу үйлдэлд нэгдэх бус сөрөх учиртай. Түүний эсрэг хамтдаа тэмцэх итгэл үнэмшил сул байгаа нь авлига “хөөсрөх” шалтаг болсоор. “Бизнесийн дарамт, сүүдрийн эдийн засгийг арилгах. Мөн өсөлтийг дэмжсэн татварын шинэчлэл хийх” шаардлагатай ажил байгааг Ерөнхийлөгч Засгийн газарт сануулсан.

Бизнесийн орчинд үүрлээд буй авлигыг бууруулах олон сонголт бидний өмнө бий. Тухайлбал, судалгаанд оролцогчдын 62.7 хувь нь шударга зарчмаар ажиллах. Мөн авлигач улстөрчдийн эсрэг компанит арга хэмжээ явуулах. Хэвлэл мэдээллийнхэнд авлигын талаар мэдээлэл өгөх зэргээр авлигыг “цэвэрлэх” боломжтой хэмээн үзжээ.Та авлигын эсрэг ямар сонголт хийх вэ. ■

Бизнесийн үйл ажиллагаанд хамгийн их саад учруулж байгаа төрийн байгууллагууд /салбараар/

	Нийт	Үйлчилгээ	Худалдаа	Үйлдвэрлэл	Барилга угсралт
Мэргэжлийн хяналтын газар	27.3%	18.7%	18%	35.4%	62.5%
Газар кадастрын алба	6.1%	4.4%	2%	6.3%	17.5%
Цагдаа	7.9%	13.2%	6%	6.3%	0%
Татварын алба	34.5%	29.7	44%	35.4%	25.0%
Гааль	14.8%	14.3%	29%	6.3%	7.5%
Хот тохижилтын алба	1.2%	1.1%	1%	4.2%	0%
Ариун цэврийн алба	2.4%	1.1%	2%	6.3%	0%
Орон нутгийн захиргаа	9.7%	11.0%	10%	8.3%	7.5%
Бусад	3.6%	8.8%	1%	4.2%	0%
Мэдэхгүй/ хариулаагүй	13.3%	22.0%	10%	10.4%	7.5%

Бизнесийн үйл ажиллагаан дахь гол бэрхшээлүүд /компанийн хэмжээгээр олон сонголттой/

Өндөр татвар	61.3%	54.1%	59.6%
Албан хураамж	16.7%	16.5%	12.8%
Албан бус хураамж	21.3%	14.3%	10.6%
Түр зуурын хориг, саад	12.7%	17.3%	19.1%
Байнгийн хориг, саад	9.3%	13.5%	8.5%
Мэдээллийн хүртээмж ба чанар	10%	9.8%	10.6%
Зөвшөөрөл, лиценз олголт ба сунгалт	34.7%	30.8%	38.3%
Ажиллах хүчний мэргэжлийн чадвар хангалтгүй	17.3%	25.6%	36.2%
Тээврийн хүртээмж ба үнэ	10%	21.1%	2.1%
Өрсөлдөөн	8%	14.3%	12.8%
Стандартчлалын шаардлага	5.3%	5.3%	10.6%
Хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл хомсдолтой	9.3%	9%	12.8%
Зээл авах боломж	29.3%	15.8%	12.8%
Менежментийн сургалт хангалттай бус	6%	2.3%	4.3%
Зах зээлийн судалгаа хангалттай бус	3.3%	5.3%	4.3%
Бусад	1.3%	1.5%	0%
Бэрхшээл байхгүй	0%	1.5%	0%
Мэдэхгүй/Хариулаагүй	2.7%	3.8%	0%

Эх сурвалж: АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг

ECONOMY TV STUDIO

НЭВТРҮҮЛЭГ

РЭТ РК

РЭКЛАМ

СУРТАЛЧИЛГАА

МЭРГЭЖСЭН БАГ
МЭРГЭШСЭН СТУДИ



Эдийн засгийн цаад агуулга нь амьдрал гэх. Эсрэгээр нь, амьдрал өөрөө эдийн засаг гэж ч тодорхойлдог. Ямартай ч тэд хүйн холбоотой гэдэг нь хөдөлгөөнгүй үнэн.

Гагцхүү энэхүү нандин холбоос, тэрхүү ээдрээтэй харилцааг дүрслэхийн хамт эдийн засаг амьдралд хэрхэн бууж, амьдрал эдийн засгаар яаж хөглөгдөж байгааг өгүүлэх нь "Economy" ТВ студийн зорилго юм.

Эдийн засаг бол удирдах ажилтны хувьд ойрын хамтрагч нь байхад энгийн иргэн түүнийг ангид ертөнц мэтээр төсөөлөх.

Тэгвэл бид бүхий л давхаргынхны эрх ашгийг хөндөж, бүх салбарынхны байр суурийг мэргэжлийн төвшинд, мэргэшсэн хэмжээнд тусгана.

Тиймээс эдийн засагт ойр танд, эдийн засгаас хол танд ч манай хаалга нээлттэй.



"Mongolian Economy" сэтгүүлийн дэргэдэх ECONOMY ТВ студи

Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, VI хороо, Их сургуулийн гудамж. AB center: 503 тоот УТАС : 70115476

ЗЭЭЛИЙН БАТЛАН ДААЛТЫН САН

ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ ЗЭВСЭГ



Э.ЗОРИГТ

Зээлийн батлан даалтын сангийн гүйцэтгэх захирал Ш.Алтанхуягтай тус сангийн үйл ажиллагаа болон олон улсын туршлага, цаашид хийх ажлынх нь талаар ярилцлаа.

-Танай санг үйл ажиллагаагаа эхлүүлснээс хойш таг чиг болчихлоо гэх шүүмжлэл байна. Тэгвэл батлан даалтын сан нэг жил гаруй хугацаанд ямар ажил амжуулсан бэ?

-Бидний гол зорилго бол банкнаас зээл авахыг хүссэн боловч барьцаа хөрөнгө нь дутагдалтай байгаа жижиг, дунд үйлдвэрлэл /ЖДҮ/ эрхлэгчдэд зээлийн батлан даалт гаргаж өгөх юм. Бид таг чиг болоогүй ээ, ажлаа ч хангалттай түвшинд хийж байгаа. Одоогийн байдлаар 9.1 тэрбум төгрөгийг 39 зээлд 3,2 тэрбумын батлан даалт гаргаад байна. Сүүлийн үед сангийн үйл ажиллагааг өргөтгөх, олон улстай хамтран ажиллах тал дээр цөөнгүй ажлыг эхлүүлээд байна. Саяхан Зүүн Азийн зээлжилтийг дэмжих холбоо буюу “ACSIC”-ийн 26 дахь чуулганд оролцоод ирлээ. Тус байгууллага нь 1987 онд байгуулагдсан. Өдгөө Азийн ЖДҮ эрхлэгчдийг дэмжих батлан даалтын сангуудын хамгийн том холбоо юм. Тус холбоонд өнөөдрийн байдлаар 11 орны 16 байгууллага гишүүнээр элсэн орсон байна. Харин манай сан ажиглагч гишүүнээр элсэх хүсэлтээ гаргасныг тус холбооны зүгээс нааштай хүлээж авсан. Мөн Азидаа эдийн засгаараа тэргүүлж байгаа Япон, Солонгос, Тайвань, Малайз гээд олон оронтой хамтран ажиллах санамж бичиг байгуулаад байна. Өнгөрсөн сард, БНСУ-ын Зээлийн батлан даалтын хамгийн том сан болох КОДИТ-той хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурсан. Солонгосын Зээлийн батлан даалтын сангийн төлөөлөгчид Манай улсад өнгөрсөн ес, аравдугаар сард ирж, өөрсдийн туршлагаасаа хуваалцсан юм. Энэ үеэр манай батлан даалтын сангийн үйл ажиллагааг сайжруулах талаар хэд хэдэн зөвлөмж өгсөн. Үүнд:

-Үнэлгээний аргачлалыг стандартчлах

-Шийдвэрийг түвшин түвшинд нь гаргах

-Эрсдэлийн удирдлагыг сайжруулах

-Батлан даалтын эх үүсвэрийг банк болон бусад хөрөнгө оруулагчдаас бүрдүүлэх гэх зэрэг. Энэ бүхнийг бид 2014 оны бизнес төлөвлөгөө, 2016 он хүртэлх стартегийн төлөвлөгөөндөө тусгаж ажиллана. Мөн энэ онд хөдөө орон нутагт батлан даалтын тогтолцоог оновчтой хүргэх үйл ажиллагааг эхлүүлээд байна. Эхний ээлжинд Завхан, Дорнод аймаг. Мөн нийслэлийн алслагдсан дүүрэг болох Баганаурт орон нутагт батлан даалтын сангийн үйл ажиллагааг хэрхэн нэвтрүүлэх талаар загвар арга ажиллагааг эхлүүлнэ.

-БНСУ-ын эдийн засгийн өсөлтийн гол хөшүүрэг нь ЖДҮ эрхлэгчид байдаг. Төр засаг нь ч тэднийгээ сайн дэмждэг. Тэгвэл тус улсын Зээлийн батлан даалт нь ЖДҮ-ээ дэмжихэд яг ямар үүрэг оролцоотой байдаг юм бол?

-Солонгост батлан даалтын гурван сан байдаг. Эхнийх нь энгийн зээлд батлан даалт гаргадаг. Дараагийнх нь дөнгөж эхэлж байгаа бизнесийг дэмжиж батлан даалт гаргадаг. Тэр дундаа технологи, инновацийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа болон явуулах гэж байгаа жижиг үйлдвэрлэгчийг дэмждэг юм билээ. Гурав дахь нь орон нутагт чиглэсэн батлан даалтын үйл ажиллагаа явуулдаг. Мөн тус улсын Зээлийн батлан даалтын сан нь батлан даалт гаргахын тулд зээлийн бичиг баримтыг өөрсдөө үнэлж, батлан даалт гаргах эсэхээ шийддэг шууд схемтэй. Тэрхүү шалгасан материалаа банкинд өгнө. Харин манай Зээлийн батлан даалтын сан банкны шийдвэрт үндэслэж батлан даалт гаргадаг шууд бус тогтолцоотой. Батлан даалтын сан зээл авах хүсэлтийг эхэлж судалж шалгах нь батлан даалтын эрсдэл хамгийн бага байх нөхцөлийг бүрдүүлдэг. Мөн хамрах хүрээ их. Нөгөө талдаа зардал өндөр, орон нутагт хүрэх боломж багасдаг юм. Монголын хувьд банкны мэдээлэлд тулгуурлан батлан даалт гаргадаг тул зардал бага хэдий ч эрсдэл өндөр байх магадлалтай. Тиймээс ирээдүйд энэ хоёр аргыг хослуулах тал дээр анхаарч ажиллана.

-Эрсдэл гэснээс Монголын Зээлийн батлан даалтын санд учирч болзошгүй эрсдэл олон байна. Тухайлбал, чанаргүй батлан даалт гаргах, хөрөнгийн эх үүсвэр төрөөс хэт хараат гэдэг ч юм уу. Тиймээс эрсдэлийг яаж бууруулах вэ. Энэ талаар ямар ажил хийж байна вэ?

-Зээлжих ёс суртахууны доголдол гэдэг зүйл байдаг. Төрөөс хувь хүний зээлийг батлан даачихсан болохоор зээлээ буцааж төлөхгүй байдал бүх улс орны ЖДҮ эрхлэгчдийн дунд нийтлэг байдаг асуудал юм. Тиймээс ийм байдал бидэнд ч гэсэн тохиолдож болзошгүй. Одоогоор ийм зүйл гараагүй л байна. Үүнээс урьдчилан сэргийлэхийн тулд бид банкнаас ирүүлж байгаа материалыг дахин шалгаж, эрсдэлтэй байж магадгүй хүсэлтийг буцаадаг. Ийм шалтгаанаар, одоогоор нийт материалын 30 гаруй хувийг буцаасан байна.

Мөн сангийн хөрөнгийг олон эх үүсвэрээс бүрдүүлэх гэдэг яах аргагүй чухал зүйл. Олон улсад арилжааны банк ашгийнхаа тодорхой хувийг албан журмаар Зээлийн батлан даалтын санд өгөх ёстой гээд хуулиараа зохицуулчихсан байдаг. Учир нь ЖДҮ эрхлэгчдэд батлан даалт гаргах нь эцсийн дүндээ банкны эрсдэлийг л бууруулж байгаа юм. Тэр утгаараа банк ашгийнхаа тодорхой хувийг Зээлийн батлан даалтын санд хөрөнгө оруулах нь зүй ёсны хэрэг гэж олон улсад үздэг. Тэр бүү хэл тухайн улсын Төвбанк нь хүртэл тус сангийн эрсдэлээс хуваалцах нь бий.

-Яг ямар улсад ийм төрлийн тогтолцоо байдаг вэ?

-БНСУ-д банк нь Зээлийн батлан даалтын санд ашгийнхаа тодорхой хувийг өгөх ёстой гээд хуулинд нь заагаад өгчихсөн байдаг юм билээ. Түүнчлэн томоохон групп, компаниуд нь сайн дурараа Зээлийн батлан даалтын санд хөрөнгө оруулдаг.

-Хөрөнгө оруулагчид батлан даалтын санд хөрөнгө оруулахын тулд тодорхой ашиг хардаг байх. Гэтэл Зээлийн батлан даалтын сан ашгийн бус байгууллага шүү дээ.

-Томоохон хөрөнгө оруулагч болон компанийн хувьд батлан даалтын санд хөрөнгө оруулна гэдэг нь нийгмийн хариуцлагаа ухамсарлаж байгаа хэрэг юм. ЖДҮ-ийн нийгэмд үзүүлэх эерэг нөлөө өндөр. Учир нь энэ салбар хөдөлмөр эрхлэлтийг дэмждэг. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нь ажилгүйдэлтэй холбоотой нийгмийн асуудлыг шийдэж чаддаг гэсэн үг. Ажилгүй хүн мөнгөгүй. Мөнгөгүй хүний эрүүл мэнд дорой, боловсрол тааруу байдаг. Мөн хийх ажилгүй хүн хулгай хийнэ, худлаа ярина. Нийгэмд байгаа аливаа асуудлын ихэнх нь ажилгүйдэл, ядууралтай холбоотой байдаг. Тэгвэл ЖДҮ эрхлэгчид ажлын байр бий болгодог. Тэр дундаа ядуурлыг бууруулах гол зэвсэг юм. Ер нь жижиг үйлдвэр хөгжихийн хэрээр томоохон пүүс компанид ажиллах гэхээр боловсрол мэдлэг, дадлага туршлага дутагддаг хүмүүсийг ажлын байраар хангах таатай нөхцөл бүрддэг юм. Түүнчлэн ЖДҮ-д ажиллагсад ихэнхдээ албан ёсоор боловсрол эзэмшээгүй байдаг. Мөн урьд нь хаа нэгтээ ажиллаж байгаагүй, ажлын туршлагагүй хүмүүсийг дадлагажуулаад ажлын байраар хангаж өгдөг. Товчхондоо эдийн засгийн эмзэг хэсэгт ажиллах боломжийг л ЖДҮ эрхлэгчид олгодог юм.

-ЖДҮ эрхлэгчдийн давуу тал юу вэ?

-ЖДҮ бол шинэ санааг анхлан гаргагчид байдаг, тэд зах зээлийн эрэлт хэрэгцээнд маш уян хатан хариу барьдаг зэрэг давуу талтай л даа.

Харин Зээлийн батлан даалтын сан ЖДҮ эрхлэгчдийг дэмждэгт л тус сангийн “ид шид” оршиж байгаа юм. Ийм учраас Зээлийн батлан даалтын санд хөрөнгө оруулах нь ядуурал гэх нийгмийн хамгийн том асуудлыг шийдэхэд тус болж буй хэрэг. Мөн тус санд хөрөнгө оруулаа гэхэд хэзээ ч тэр мөнгө алга болохгүй. Тодорхой хэмжээнд өссөөр байх болно. Тэр мөнгөөр тасралтгүй батлан даалт гаргаж, таны оруулсан хөрөнгө оруулалт урт хугацаанд нийгмийн сайн сайхны төлөө үйлчилсээр байх юм. Ийм учраас л томоохон хөрөнгө оруулагчид тус санд сайн дурараа хөрөнгө оруулах буюу нэг ёсны хандив өгөхдөө гар татдаггүй. Хөгжингүй орны Засгийн газар ч гэсэн ЖДҮ эрхлэгчдэд өгөх хөнгөлөлттэй зээл, тусламжаа барагтай бол бууруулдаггүй. Хамгийн гол нь ЖДҮ ажлын байр бий болгож байна уу гэдгийг нь л хардаг. Зээлийн батлан даалтын сан нь ч гэсэн алдагдалтай ажилласан ч батлан даалтаа гаргасаар л байдаг. Учир нь тэд л нийгмийн өмнө тулгамдаж буй зарим асуудлыг шийдэх хамгийн гол хөшүүрэг байдаг.

-Японы туршлагаас харахад »

Зээлийн батлан даалтын сангийн эрсдэлийг хувийн даатгалын компанид давхар даатгуулсан байдаг юм билээ. Манайд энэ туршлагыг хэрэгжүүлж болох уу?

-Манай орны тухайд хувийн даатгалын компаниудын санхүүгийн чадавх сул байна. Гэхдээ төрөөс нийт батлан даалтын 60 хүртэлх хувийг давхар батлан даахаар хуулиндаа заагаад өгчихсөн байгаа. Яваандаа хувийн даатгалын компанийг татан оролцуулж болно.

-Дахиад л төр. Ер нь Зээлийн батлан даалтын сан төрийн гарт, санхүүгийн эс үүсвэр нь татвар төлөгчдийн мөнгөөр л бүрдэж байна. Энэ ер нь зөв үү?

-Олон улсын жишгээс харахад ЖДҮ хөгжүүлэхийн тулд дөрвөн төрлийн дэмжлэг үзүүлдэг юм байна. Эхнийх нь хууль эрх зүйн буюу татварын таатай орчин бүрдүүлэх. Мөн төрийн байгууламжаараа буюу ЖДҮ хөгжүүлэх газар /манай улсын хувьд Хөдөлмөрийн яамны харъяа/-аараа дамжуулж төрийн бодлогыг хэрэгжүүлэх. Түүнчлэн санхүүгийн оновчтой тогтолцоо буюу Зээлийн батлан даалтын сангаар дамжуулан ЖДҮ эрхлэгчдийг дэмждэг. Бас үнэт цаасны буюу Хөрөнгийн биржээс хямд эх үүсвэр бүхий хөрөнгө босгох боломжийг нь бүрдүүлж өгдөг. Дөрөвдүгээрт, ЖДҮ-ийг дэмжих дэд бүтцийг сайн хөгжүүлэх. Энэ нь ЖДҮ-г дэмжих мэргэжлийн байгууллагуудын холбоод, тэднийг сургалт, мэдээллээр хангадаг төрийн бус байгууллагууд, зөвлөгөө өгдөг хувь хүн, санаачлагууд аль болох их дэмжих гэсэн үг.

Гурав дахь дэмжлэг болох санхүүгийн оновчтой тогтолцооны хувьд одоогоор манайд хөнгөлөлттэй зээл олгох, татварын хөнгөлөлт үзүүлэх, батлан даалт гаргах гэсэн л бодлогууд хэрэгжиж байна. Гэхдээ бүгд л хөгжлийнхөө эхний шатанд явж байгаа. Тиймээс төр хүчтэй оролцох зайлшгүй шаардлага байгаа. Тэгэхгүй бүх зүйл зах зээлийнхээ жамаар хөгжих ёстой гээд хараад байвал хөгжингүй орнуудын ард л үлдэнэ. Тийм болохоор төр хэрэгтэй үед нь оролцоод тухайн салбарыг зөв голдиролд нь оруулаад аажим аажмаар оролцоогоо багасгах зарчмаар явдаг. Ер нь хөгжиж байгаа орнуудын туршлагаас харахад ч хөгжлийн хандлага нь төр аливаа том ажлыг эхлүүлдэг юм билээ. Цаг нь болохоор бусаддаа зайгаа тавиад өгдөг. Бид ч гэсэн ийм л жишгээр хөгжих гээд байна.

-Арилжааны банк ашгийн төлөө байдаг болохоор зээл хүсэгчдэд өндөр шалгуур тавьдаг. Тэр шалгуурт тэнцдэг нь нөгөө томоохон үйлдвэрлэгчид байдаг шүү дээ. Гэтэл өнөөдөр батлан даалт гаргах материалыг банк гаргаж байна. Тиймээс Зээлийн батлан даалтын сан нөгөө л томоохон үйлдвэрлэгчдийг дэмжээд ЖДҮ эрхлэгч нараа орхигдуулаад байгаа юм биш биз?

-Манай сангийн тухайд банкнаас ирүүлсэн материалыг дахин шалгаж үздэг. Хэрэгтэй гэж үзвэл зээл хүссэн иргэдийн ажил байдалтай очиж танилцдаг. Үүнийхээ дараа батлан даалт гаргах эсэхээ шийддэг. Гэхдээ таны хэлсэн шиг асуудал үүсч магадгүй гэх болгоомжлол байсаар байна. Тийм болохоор манайхаас Зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг орон нутагт хүргэхэд анхаарал хандуулж байгаа. Энэ ажлын хүрээнд ямар нэг аймгийг сонгоод тухайн аймгаас болон Зээлийн батлан даалтын сангаас хамтран хөрөнгө босгоно. Ингээд зөвхөн тус аймагт зориулсан батлан даалт гаргаж болох юм. Мөн тус аймгийн хөгжлийн зорилго, бизнес судалгаанд тулгуурлан тухайн аймагт ямар бизнес хийвэл ашигтай байхыг тооцож үзнэ. Тэр бизнесийг эхлүүлэх ЖДҮ эрхлэгчдэд батлан даалт гаргаж, банкнаас зээл авах боломжийг нь бүрдүүлж өгнө. Ингээд ирэхээр тус аймаг нь зөвхөн өөрийн давуу талд тулгуурласан үйлдвэрлэл, бараа бүтээгдэхүүнтэй болон хөгжих боломжтой.

-Дөрвөн орны батлан даалтын сантай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан гэсэн. Тэдэнтэй хэрхэн хамтрах ажиллах гэж байна вэ?

-Малайз, Тайвань, Солонгос болон Москва хотын Зээлийн батлан даалтын сантай хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурсан. Малайз гэхэд л энэ салбартаа 40 жилийн туршлагатай. Тэдний туршлагаас бидэнд авах юм их байна. Тухайлбал, батлан даалтын сангийн хөгжлийн явцад хөгжлийн амьдралын мөчлөг гэж байдаг юм билээ. Тэгвэл энэ мөчлөгийг хэрхэн стратегийн бодлоготойгоо уялдуулах вэ гэдгийг тус улсын батлан даалтын сан хамгийн сайн мэддэг. За тэгээд тодорхой салбарт зориулсан батлан даалтыг хэрхэн гаргах. Банкуудын оролцоог хэрхэн оновчтой зохион байгуулах вэ гээд тэднээс сурах зүйл их. Харин Тайваньд батлан даалтын бүтээгдэхүүний нэр төрөл маш олон байдаг. Москвагийн сангийн хувьд Монголын ЖДҮ эрхлэгчдийг экспортлогч болгох чиглэлийн дагуу хамтран ажиллах боломжтой. Тухайлбал, Монголын ЖДҮ эрхлэгчид Улаан-Үүд рүү гаргах бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг бол эргэлтийн хөрөнгө дутаж байгаа үед нь Зээлийн батлан даалтын сан зөвхөн тэр хэсэгт зориулсан батлан даалт гаргаж зээл авах боломжийг нь бүрдүүлдэг байж болох юм. Нөгөө талаас, манайхаас бүтээгдэхүүн авах сонирхолтой Оросын талын ЖДҮ эрхлэгч хэрвээ эргэлтийн мөнгөгүй бол тус улсын батлан даалтын сан нь тэднийг дэмжиж болох юм. Энэ мэт харилцан уялдаатай хоёр талын худалдааг дэмжих боломж бий.

-ЖДҮ эрхлэгчдийн зээлжих зэрэглэлийг хэрхэн сайжруулж болох вэ?

Солонгост батлан даалтын сан нь зээлжих 15 шатлалын зэрэглэлтэй байдаг. Тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу зээлжих зэрэглэл нь сайжирдаг. ЖДҮ эрхлэгчид бага багаар зээлжих зэрэглэлээ сайжруулж чадах юм бол хүү багатай, урт хугацаатай зээл авах болон бусад төрлийн боломж нь нэмэгддэг. Тийм болохоор зээлжих зэрэглэлээ өсгөхийн төлөөх ЖДҮ эрхлэгчдийн эрүүл өрсөлдөөн тун чухал. Энэ хэрээр ЖДҮ эрхлэгчид чадавхжиж байдаг юм байна. Бид энэ жишгээр ойрын үед Монголын зах зээлд тулгуурласан зээлжих зэрэглэл бий болгохоор ажиллаж байна. Үүний тулд бидэнд маш их мэдээллийн бааз суурь хэрэгтэй. Тиймээс хөгжлийнхөө эхэн үед байгаа Зээлийн батлан даалтын санг хөлд оруулахын тулд олон улсын туршлагаас судлах, хамтран ажиллах, мэдээлэл цуглуулах гээд олон ажлыг хийгээд явж байна. ■

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭР

ИМПОРТЫГ ОРЛОХ ҮЙЛДВЭР





Фотог Зохиогч

Нэг машин өдөрт 200 гаруй хос бээлий үйлдвэрлэдэг

Ч.ЛУТАА

Хэрвээ нарийн технологи гэж мэдэхгүй XIX зууны хүн эс бөгөөс учир ойлгохгүй жаахан хүүхэд А.Цогтын жижигхэн үйлдвэрээр ороод гарвал эгээ л үлгэрт гардаг шидэт гэрт орчихов уу гэлтэй. Ээрсэн утас, нэхмэлийн зүү, хэрээсний машин гээд бүх зүйл нь хэн нэгний оролцоогүйгээр чөлөө завгүй ажиллана. Хэдхэн хормын дараа цасан цагаан ажлын бээлий бэлэн болоод сагсанд гулсаад орчихно. А.Цогтын бага охин “Аваа манай үйлдвэр ид шидтэй тиймээ. Өөрөө ажиллаад л бээлий хийгээд байдаг” гэж асуусан аж. Арга ч үгүй биз. Тэнд хэн ч байхгүй боловч бээлий үйлдвэрлээд байдаг юм чинь.

Ажлын бээлий хийдэг үйлдвэртэй болох хүсэл зорилгоо өнгөрсөн хавар биелүүлсэн А.Цогт гэх залуу өдгөө 35 настай. Саяхан ЖДҮ эрхлэгч болсон нэгэн. Өмнө нь хувираа бизнес хийх хэцүү гэх бусдын яриаг сонсоод үйлдвэртэй болох санаагаа хойш тавьсаар иржээ. Тэрбээр “Өмнө нь би Заамрын уурхайд машинист хийдэг байсан. Уурхайн ажил ер нь хэцүү. Эрсдэл өндөр, ачаалал их. Эхнэр цэцэрлэгийн багш ажилтай. Бас л цаг наргүй. Тийм болохоор ар гэрийн ажил хаягдаж, үр хүүхдийн хүмүүжил боловсролд эцэг, эхийн зүгээс тавих анхаарал суларч ирсэн. Тиймээс л хувираа бизнес хийх мөрөөдлөө биелүүлэхээр зүтгэсэн” гэсэн юм. Энэ шаардлагын дагуу эхнэр, нөхөр хоёр хуримтлуулсан 10 сая төгрөгөөр бээлий нэхдэг хоёр машин авч үйлдвэрийнхээ үйл ажиллагааг эхлүүлсэн байна. Цогтын эхнэр Д.Болормаа “Хоёр машинаа үүдний амбаартаа байрлуулаад бээлийгээ хийж эхэлсэн. Нэг машин өдөрт 200 гаруй бээлий хийдэг. Тэгээд нөхөр бид хоёр өнжөөд нэг удаа 800 гаруй бээлийг захын хорооллын хүнсний дэлгүүрээс эхлээд бүх техникийн, барилгын, хүнсний захуудад борлуулж эхэлсэн. Нэг хос бээлийг 250 төгрөгөөр бөөндөхөд наймаачид дуртай авдаг. Урдаас авдаг бээлий хэдий хямдхан ч чанар муутай байдаг болохоор хүмүүс манай бээлийг авахдаа дуртай байдаг” гэв. Эхлүүлсэн ажил нь урагштай байсан болохоор залуус үйлдвэрлэлээ өргөтгөхөөр шийдэж тус бүр нь таван сая төгрөгийн үнэтэй гурван машин худалдаж авсан байна. Гэтэл тэдэнд эргэлтийн мөнгө дутжээ. Тэгээд л банкны хаалгыг тогшиж, үүдийг нь сахьдаг ажилтай болсон гэнэ. Өөрсдийн байгаа бүх эд хөрөнгөө барьцаанд тавиад тэдэнд таван сая төгрөгийн л зээл банкнаас өгсөн байна. Гэтэл хамгийн багадаа л 10 сая төгрөг хэрэгтэй байсан аж. ››

Гомдоллох хэрэггүй

Эргэлтийн мөнгөний эрэлд гарсан эхнэр нөхөр хоёрт эхэндээ банкны зээлийн өндөр босго хатуудаж, төрийн хайр ивгээл үгүйлэгдэж байжээ. ЖДҮ эрхлэгчдээ дэмжихгүй байна. Бидэнд хөнгөлөлттэй зээл олдохгүй нь гэх бодол олон удаа төрж, шантрах үе цөөнгүй байсан аж. Төөрч явсаар нэгэн өдөр харьяа дүүргийнхээ Хөдөлмөрийн хэлтэст хандсан нь тэдний амжилтын хөтөч болжээ. А.Цогт “Мэдээлэлгүй хүн өнөөгийн нийгэмд хол явахгүй юм билээ. Өнөөдөр юу хийхээ мэдэхгүй мөртлөө зээл хүссэн. Мөнгөтэй болоод нэг юм хийнэ дээ гээд яриад яваа хүн олон байна. Мөн бид хоёр шиг бизнес хийх гээд бор зүрхээрээ зүтгэж яваа нэг хэсэг бий. Тэр хүмүүст олон бэрхшээл тулгардаг. Тэгээд зарим нь цөхөрдөг, гомдоллодог. Гэтэл Засгийн газраас ЖДҮ эрхлэгчдээ дэмжих тал дээр олон ажил хийж байгааг бид мэддэггүй юм билээ. Тиймээс ЖДҮ эрхлэхээр шийдсэн хүн эхлээд харьяа дүүргийнхээ Хөдөлмөрийн хэлтэст л хандах хэрэгтэй. Тэндээс ЖДҮ гэж юу вэ, бизнесээ хэрхэн амжилттай удирдах вэ, хөнгөлөлттэй зээлд хамрагдах боломж, Зээлийн батлан даалтад хэрхэн хамрагдах вэ гээд олон талын мэдээлэл авах боломжтой. Бүр долоо хоногийн үнэ төлбөргүй сургалтад хамрагдаж, гэрчилгээ авдаг” гэсэн юм. ЖДҮ эрхлэгчдийг дэмжих учиртай хөнгөлөлттэй зээл жинхэнэ эзэддээ хүрч чадахгүй байна гэх гомдол өнөө хэр нь тасардаггүй. Дээлээ гандтал банкны үүд сахиж зээл хүссэн ЖДҮ эрхлэгчид олон. Тэгвэл саяхан ЖДҮ эрхлэгч болсон А.Цогтын гэр бүл “Гомдоллох хэрэггүй. Харин зөв газраа яваад оч. Тэнд танд туслах хүн олон байгаа” гэж зөвлөсөн юм. Д.Болормаа “Өмнө нь нөхөр бид хоёр ЖДҮ эрхэлдэг хүмүүсийн амнаас болохгүй, бүтэхгүй байна. Төр засаг дэмжихгүй байна гэдэг үгсийг сонсоод халширдаг байлаа. Гэтэл яг үнэндээ төр иргэдээ дэмжээд байгаа юм билээ. Харин тэр дэмжлэгийг олж мэдээгүй хүн олон байх шиг санагдсан” гэж. Өдгөө Баянгол дүүргийн есдүгээр хороонд орших тэдний жижигхэн үйлдвэр сарын 5-6 сая төгрөгийн орлоготой ажиллаж байна. Олсон орлогоосоо 460 мянган төгрөгийг сар бүр банкны өрөнд өгнө. Эргэлтийн хөрөнгөө гаргаж авна. Гурван хүүхдийнхээ ирээдүйд зориулж хэдэн төгрөг цааш нь хийчихнэ. Товчхондоо тэдний амьдрал дутагдах гачигдахын зовлонгүй аз жаргалтай байна.

Цахим ертөнцөд тавтай морил

Татвар гэдэг “хадны мангаа” байдаг гэж дуулснаас цаашгүй А.Цогт татвар төлөгч болохоос айж байсан гэнэ. Учир нь бизнесийн орчинд хөл тавьсан тэд ирэх арванхоёрдугаар сараас татвар төлөх учиртай аж. Гэхдээ тэдний санхүүгийн тайлан тооцоог гаргадаг Цогтын ээж Ё.Билгүүн түүний айсан сэтгэлийг тайвшруулжээ. Билгүүн “Би насаараа төрийн байгууллагад ажилласан. Олон ч удаа санхүүгийн тайлан өгөх гэж хонон өнжин дугаарлаж байлаа. Хоёр жилийн өмнө гэхэд л хувийн бизнесийнхээ санхүүгийн тайланг татварын газар өгөх гэж бүтэн өдөр дугаарлаад өгч чадалгүй буцсан. Маргааш нь хар өглөөгүүр ирээд арай гэж тайлангаа өгөх гэтэл цайны цаг нь болоод буцаж байлаа. Гэтэл энэ удаа хоёр хүүхдийн тайлан тооцоонд дэм болох гээд санхүүгийн тайланг нь гаргаад харьяа татварын газар өгөхөөр очтол бүх үйлчилгээ нь цахим болчихож. Хүнтэй харьцахгүй, ууртай ажилтантай учраа олох гэж маргахгүй, дугаарлаж зогсож цаг алдахгүй интернэт ороод л бол оо. Амар юм байна. Ер нь төрийн бүх үйлчилгээг цахим болгочихвол нөгөө ихүнд суртал үгүй болох юм байна” гэв.

Ханш гэдэг дайсан

Гомдоллох дургүй гэр бүлийнхэнд ганц том дайсан байдаг аж. Тэр нь валютын ханш. Ханшийн савлагаанд хамаг ашгаа гөвөөд дуусч байгаа олон бизнесмэний нэг бол А.Цогт. Учир нь түүний үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүний түүхий эд нь урд хөршөөс орж ирдэг. Д.Болормаа “Валютын ханш чангарахын хэрээр гаднаас авдаг бараа бүтээгдэхүүний үнэ өндөр болдог. Хоёр гуравхан сарын өмнө 2-3 сая төгрөгөөр авдаг байсан нэг тонн утас өнөөдөр дөрвөн сая төгрөг болчихоод байна. Дээрээс нь бээлийгээ хийдэг гялгар уут боодол нь 3500 төгрөг байсан. Гэтэл одоо 4800 төгрөг болчихоод байгаа” гэсэн юм. Үндэсний мөнгөн тэмдэгтийн ханш сул байх нь Монгол шиг импортоор “амь зогоодог” улсын инфляцийг хөөрөгддөг. Өнөөдөр 250 төгрөгийн үнэтэй байсан өндөг 400 төгрөг болтлоо өссөн нь үүнтэй л холбоотой. Гэтэл зах зээлийн өчүүхэн хэсгийг эзэлдэг Цогтын үйлдвэрлэдэг ажлын бээлийний үнийг нэмэх боломж хомс аж. Цогт “Бид бүтээгдэхүүний үнээ нэмж болдоггүй. Учир нь Хятадаас орж ирдэг бүтээгдэхүүн бидний үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүнээс харьцангуй хямдхан байдаг. Мөн байнгын худалдан авагчдаа алдахгүйн тулд үнээ тогтвортой байлгах шаардлагатай. Гэтэл валютын ханшаас болоод бидний ашиг буураад байна. Ер нь бид дотооддоо үйлдвэрлэгч болохын тулд эхлээд түүхий эдээ бэлтгэдэг байх ёстой юм билээ. Утсаа, зүүгээ, резинээ, уутаа гээд бүх юм аа урдаас авдаг байж бид дотооддоо бээлий хийсэн гэх нь утгагүй юм байна. Нэр нь дотоодын үйлдвэрлэгч болохоос нэдэр дээрээ валютын ханшаас хараат, Хятадын зах зээлээс шууд хамааралтай хэвээр л үлдэж байна” гэлээ. Түүний хэлснийг бодоод үзэх л асуудал.

Валютын ханш өнөөдөр инфляцийг хөөрөгдөж, ам.долларын зээлтэй бизнес эрхлэгчдийн халаасыг хоосолж, ЖДҮ эрхлэгчдийн ашгийг сорж байна. Тиймээс Засгийн газар, Монголбанк энэ тал дээр яаралтай арга хэмжээ авахгүй бол болохгүй нь. Төгрөгийн ханш сулрах нь дотоодын үйлдвэрлэгч нарт ашигтай гэх эдийн засгийн онол бий. Гэтэл А.Цогтын хэлсэнчлэн үйлдвэрлэгч гэдэг нэртэй импортлогчид Монголд олон байгаа цагт тэдэнд энэ онол таарахгүй нь. Тиймээс монголчууд ЖДҮ-ийг хөгжүүлэх, үйлдвэрлэгч болох, экспортлогч орны тоонд орох мөрөөдлөө биелүүлэхийн тулд түүхий эдээ дотооддоо бий болгоход анхаарах хэрэгтэй гэдэг нь харагдаж байна.

Засаг төрийг харалган байгаа талаар шүүмжлэх нь олон. Гэхдээ А.Цогт шиг зөв зүйтэйг нь яриад зөрүү бурууг нь шүүмжлэх хэсэг ч бас байна. Тиймээс төр, засгийн хүмүүс маань энэ мэт иргэдийнхээ үгийг авах нь аль аль талдаа хэрэгтэй биз ээ. ■

ҮНЭ ХАНШ

ЭЗЭГТЭЙ НАРЫН БУХИМДАЛ

Г.ОРХОН

Бүх төрлийн бараа, бүтээгдэхүүний үнэ нэмэгдсээр байгааг иргэд алхам тутамдаа мэдэрч, бухимдангуй явна. Тэр дундаа өрхийн “Сангийн сайд” гэгддэг эзэгтэй нар өдөр тутмын хүнсээ базаах, шинэ жилийн гоёл чимэг сонирхох гээд дэлгүүр хэсэх нь ихэсч байгаа нь мэдээж. Аяга, таваг угаагч шингэнээс авахуулаад алим жимсний үнийг ч анддаггүй эзэгтэй нарын хувьд бараа, үйлчилгээний үнийн өсөлттэй байнга нүүр тулж, бухимдалтай байна.

“Mongolian Economy” сэтгүүл иргэдийн амьдралд томоохон дарамт үүсгэж буй үнийн өсөлтийг цаасан дээр буулгалаа.

Улсын хэмжээнд инфляци 10.8 хувьтай байна. Монголбанкны мөнөөх зорилтот найман хувь үнийн өсөлтийн “тоосонд” дарагдав. Иргэдийн худалдан авалт муудаж, иргэн Доржийн хэтэвч эрс нимгэрч байна. Нийслэлчүүдийн олонх нь хүнсээ цуглуулдаг “Хүчит Шонхор”, “Барс” зэрэг томоохон захуудаар явж, өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүний үнийн судалгаа хийлээ. Чингэхдээ сонирхсон барааныхаа одоогийн үнийг нэг сарын өмнөх үетэй нь харьцуулж үзлээ. Томоохон захуудаар явж байхад худалдан авагчид төдийгүй худалдагч нар ч барааны үнэ огцом өсөж байгаа талаар учирлаж байв.

Хүнсний бүтээгдэхүүн төдийгүй гэр ахуйн барааны үнэ ч өсчээ. Тухайлбал, эзэгтэй нарын өргөн хэрэглэдэг гурван ширхэгтэй гал тогооны алчуур л гэхэд 1000 төгрөгийн үнэтэй болж. Өмнө нь 800 ▸▸



Фотог Э.Зориг

“Бөмбөгөр” худалдааны төв

Сүү, сүүн бүтээгдэхүүн: /литр, кг/

Бүтээгдэхүүний төрөл	Үнэ			
	“Хүчит Шонхор”	“Бөмбөгөр”	“Барс”	“Баянзүрх”
Ааруул /чихэртэй/	7000	8000	7000-8000	8000
Чихэргүй ааруул	5000-6000	7000-10000	6000	6500
Бяслаг	7000	8000	7000	8500
Шар тос /монгол	8000	8500	8000	10000
Шар тос /сингапур/	3500	4000	3500	4000
Зулын тос	3500	4500	3500	4000
Орос масло	3000	3500	3000	3500
Өрөм	5000	6000	6000-6500	6000-7000
Аарц	1200	2000	1500	1800
Цөцгий	5000	7000	6000	7000
Өөхөн тос	800	900	600	1200
Сүү	1500	1500	-	1400

төгрөгийн үнэтэй байжээ. “Бөмбөгөр” худалдааны төвийн гэр ахуйн барааны тасгийн худалдагч Б.Цэцэгээ “Энэ гал тогооны алчуур өмнө нь манай лангуунд 620 төгрөгийн бөөний үнээр нийлүүлэгддэг байсан. Гэтэл одоо 900 төгрөгөөр ирдэг болсон. Долларын ханшийн өсөлттэй холбоотой байдаг юм уу, импортоор авдаг бүх л төрлийн барааны үнэ өсөж ирээд байна шүү дээ. Тухайлбал, хогийн тосгуур шүүр гэхэд л өмнө нь нэг бүр нь 3500 төгрөгөөр нийлүүлэгдээд, бид 4000 төгрөгөөр борлуулдаг байсан. Тэгвэл одоо 4500 төгрөгөөр аваад, 5000 төгрөгөөр зарж байгаа” хэмээн учирлав. “Хүчит Шонхор” захын гэр ахуйн барааны худалдагч Б.Энхжаргал “Бид урдаас бараа авахаасаа илүү хүмүүст худалдахад хэцүү байна. Үнийн өсөлт маш хүнд тусч байна. Бүх бараа дунджаар 500-1000 төгрөгөөр өссөн” гэлээ.

Чухам үнийн өсөлтөд юу нөлөөлөв. 1740 төгрөг давж буй ам.доллар болон 286 төгрөгөөс буухгүй байгаа юанийн ханшийн өсөлт иргэдэд хүндхэн ачаа болж буй.

Хүнсний ногоо: /кг, төгрөгөөр/

Төрөл	Үнэ			
	“Хүчит Шонхор”	“Бөмбөгөр”	“Барс”	“Баянзүрх”
Монгол төмс	500-600	500-600	600	600
Монгол лууван	1000	1000-1200	1000	1000
Монгол сонгино	1500	1500	1800	2000
Хятад сонгино	1200	-	1200	1000
Хятад сармис	3500	-	3000	3500
Монгол сармис	20000	-	-	15000
Монгол манжин	1500	1500	1500	1500
Монгол байцаа	1000	1500	1200	1500

Ургамлын тос: /литр, төгрөгөөр/

Төрөл	Үнэ			
	“Хүчит Шонхор”	“Бөмбөгөр”	“Барс”	“Баянзүрх”
“Sunny Gold”	3500	3200	3100	3300
“Кларина”	3000	3000	2900	3000
“Олейна”	4000	3700	3800	4000
“Яанта”	3000	2700	2900	3000
“Simply”	3500	3200	3500	3600

Өндөг: /1 ширхэг/

Төрөл	Үнэ			
	“Хүчит Шонхор”	“Бөмбөгөр”	“Барс”	“Баянзүрх”
Орос “НВЦ”	390	390	380	400
Монгол	380	380	360	380-400

Импортын бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтийг даган үндэсний үйлдвэрлэлийн бараа, бүтээгдэхүүний үнэ өсөж буй нь хачирхалтай. Нэгэн жишээ дурдъя.

Манай ажлынхан Нийслэлийн шүүхийн эсрэг талд байрлах “Анд” кафед орж, банштай цай уух дуртай. Эдний банштай цай амт сайтай, харьцангуй хямдхан учраас тэр. Том аягатай мөртлөө 3000 төгрөгийн үнэтэй. Есдүгээр сараас хойш эднийхээр үйлчлүүлээгүй юм байна. Тэгээд саяхан ороод, банштай цайгаа уух гэтэл үнэ нь даруй 6000 төгрөг болжээ. Будааг эс тооцвол банштай цай үндэсний үйлдвэрийн түүхий эдээр бүтдэг хоол. Мах, гурил, сүү. Аль алиныг нь дотоодоосоо авч болох. Гэтэл үнэ нь ийн өссөнийг юу гэж ойлгох вэ. Түүнчлэн Монгол Улс 2008 онд “Атрын III” аян зарласнаас хойш улаан буудайн хэрэгцээгээ дотоодын үйлдвэрлэлээр зуун хувь хангадаг болсон. Улмаар улаан буудай экспортлох тухай яригдаад хоёр, гурван ч жилийн нүүр үзэж буй. Өнгөрсөн намар ч бололцооны ургац хураасан. Гэтэл “Бөмбөгөр”, “Баянзүрх” зэрэг захад дотоодын гурилын үнэ нэг сарын өмнөх үеэс кг тутамдаа 70-80 төгрөгөөр өссөн байх юм. Оросын “Цесна” гурил 10 кг-тай нь 19000, 25 кг нь 35000 төгрөг, “Алейка” таван кг нь 6500, 10 кг нь 11000-13000 төгрөгийн үнэтэй байна. “Хүчит Шонхор”, “Барс” захын гурилын худалдагчдын хэлж буйгаар “Цесна” гурилын үнэ долоо хоног бүр өөрчлөгдөж, тогтворгүй байгаа аж. Тус гурил дээрх захуудын гурилын лангуун дээр нэг кг нь сарын өмнө 1240 төгрөгийн үнээр нийлүүлэгддэг байсан бол энэ сарын 27-ны байдлаар

1360 төгрөг болжээ.

Мөн хүнсний захуудад монгол өндөг ширхэг нь 380-400 төгрөгийн үнэтэй байна. “Хүчит Шонхор” хүнсний захын худалдагчийн хэлж буйгаар орос НВЦ өндөг одоогоос сарын өмнө нэг ширхэг нь 290 төгрөгөөр нийлүүлэгддэг байсан бол өнөөдөр ширхэг тутамдаа 70 төгрөгөөр өсчээ. Түүнчлэн үнэ нь огцом өсөлттэй хүнсний бүтээгдэхүүн ургамлын тос санагдлаа. Олон орноос орж ирдэг, олон төрөлтэйг ч хэлэх үү, үнэ нь өөр өөр. Тухайлбал, “Хүчит Шонхор” захад байгаа үнийг нь сонирхоод үзэхэд, “Sunny gold” тос нэг сарын өмнө 2500 төгрөгөөр нийлүүлэгддэг байсан бол өнөөдрийн байдлаар 3000 төгрөгөөр, мөн 2300 төгрөгийн үнэтэй байсан “Яанта” 2800 төгрөгөөр, “Simply” 2700 төгрөг байснаа 3350 төгрөгөөр нийлүүлэгдэж байгаа аж. Үүн дээр худалдагч нар лангууны үнээ нэмнэ шүү дээ. За тэгээд төрөл бүрийн хоол амтлагч хүртэл үнэд оржээ.

Хүнсний бүтээгдэхүүнээс будаа, элсэн чихэр, махны үнэ харьцангуй тогтвортой байна. “Хүчит Шонхор” захад хонины ястай махны үнэ өнгөрсөн сарын сүүлийнхээс кг тутамдаа 500 төгрөгөөр хямдарсан байна.

Уншигч танд нийслэлийн томоохон хүнсний захууд дахь өргөн хэрэглээний барааны үнийн харьцуулалтыг өнгөрсөн сарын 28-ны байдлаар хүснэгтээр хүргэе. ■

Мах /кг. төгрөг/

Төрөл	Үнэ				
		“Хүчит Шонхор”	“Бөмбөгөр”	“Барс”	“Баянзүрх”
Үхэр	Цул	7300-9000	9500	8500-10000	8000-8500
	Ястай	7000-7200	7500	7000-7500	7500
Адуу	Цул	5500-5800	6500	6800	5800-9500
	Ястай	5300-5500	6500	6800	5800-7500
Хонь	Цул	6500-7000	7000	9000	6500-7000
	Ястай	5500-6000	6500	8000	5800-6000
Ямаа	Цул	5500	6500	6500	5800
	Ястай	4800	-	-	4500
Тэмээ	Цул	5500	-	-	5500

Гурил: /кг, төгрөгөөр/

Төрөл	Үнэ								
		“Хүчит Шонхор”		“Бөмбөгөр”		“Барс”		“Баянзүрх”	
	10 кг	25 кг	10 кг	25 кг	10 кг	25 кг	10 кг	25 кг	
“Улаанбаатар”	дээд	11000	25000	11000	25000	10000	25000	11000	25000
	I	7500	17500	7500	17500	7200	17000	7000	17500
	II	5000	10000	5000	10000	-	10000	-	-
“Алтан тариа”	дээд	11000	25000	11000	25000	10000	25000	11000	24000
	I	7500	17500	7500	17500	7200	17000	7000	17500
	II	5000	10000	5000	10000	-	10000	-	-
“Атар”	дээд	11000	25000	-	-	10000	25000	-	24000
	I	7500	17500	-	-	7200	17000	7500	-
	II	5000	10000	-	-	-	10000	-	-
“Хурх”	дээд	14000	29000	-	-	-	28000	-	-
	I	8500	19000	-	-	-	18000	-	-
	II	5500	11000	-	-	-	10000	-	-

БИЗНЕС ЗӨВЛӨГӨӨ

ХЭРХЭН САЙН КОМПАНИТАЙ БОЛОХ ВЭ



Лесли Дак – АНУ-ын “Walmart” сүлжээ дэлгүүрийн гүйцэтгэх дэд захирал асан (2006 оны наймдугаар сараас энэ оны зургаадугаар сар хүртэл)

Р.ГАНТУЛГА

Аливаа компанийн эсрэг буруу ойлголт нийгэмд тархах үед удирдлагын зүгээс олон нийттэй харилцах ажилтан авч ажиллуулах нь нийтлэг тохиолддог зүйл. Ингэснээр хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан олны дургүйцлийг хүргэсэн таагүй мэдэгдэл хийж эхэлдэг. Компанийн гүйцэтгэх захирал “Бид буруу ойлголцсон юм шиг байна. Өөрсдийнхөө талаар зүгээр л сайн, сайхан зүйл илүү их ярих хэрэгтэй байж” гэж хэлэх нь бий.

Энэ нь зарим талаараа үнэний хувьтай байж болох. Намайг анх “Walmart” сүлжээ дэлгүүрт ажилд орж байх үед үр ашигтай үйл ажиллагаа явуулж, хэрэглэгчдээ сэтгэл ханалуун байлгахад ихээхэн анхаардаг байв. Үүний дүнд АНУ-ын хэмжээнд хамгийн том сүлжээ дэлгүүр болж чадсан. Гэтэл зарим гүжирдлэгийн шинжтэй олон нийтийн дунд гаргасан ямар ч үндэслэлгүй цуу яриа одоо хэр нь чих дэлссээр л байна. Ингээд бодохоор “Walmart” сүлжээ дэлгүүрийн түүхийг илүү сайн, сайхнаар ярих хэрэгтэй байж л дээ.

Гэхдээ та компанийнхаа хэтийн төлөв, алсын хараг тайлбарлаад эхлэхээр олон нийт шууд л сайнаар хүлээгээд авчихна гэж бодож байгаа бол маш том эндүүрэл. Зөвлөхөөр олон жил ажилласны хувьд юу нь болохгүйг би сайн мэддэг болсон. Хэрвээ та компаниа илүү сайн болгож, сайжруулах талаар юу ч хийгээгүй бол компанийнхаа талаар хэчнээн сайн зүйл яриад ямар ч нэмэргүй. Өөрөөр хэлбэл таны үг, үйлдэл зөрж байна гэсэн үг.

АНУ-д 2007 онд Катрина далайн хар шуурга болсон. Энэхүү байгалийн гамшиг “Walmart”-ийн хувьд шийдвэрлэх мөч байсан гэж хэлж болно. Уг гамшгийн үеэр манай дэлгүүр хүмүүст хоол, хүнс, түргэн тусламжийн зүйлс, бэлэн мөнгө хүргэж өгөх ажилд дайчлагдсан юм. Тухайн үед үүнийг хийх нь зөв эсэх тал дээр бидэнд ямар ч эргэлзээ байгаагүй. Энэ бол гарцаагүй зөв зүйл гэдэг нь ойлгомжтой байв. Үүний ачаар бизнестээ жинхэнэ өөрчлөлт хийх сайхан боломж байгааг бид олж харсан юм. Энэ явдлаас хойш хоёр сарын дараа тухайн үед гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан Лий Скотт хүмүүсийн сэтгэлд хүрсэн зүйлийг хэлж билээ.

Тэрбээр “Бид цаг үргэлж өөрсдийн хамгийн сайн, сайхнаа зориулах үед энэ нь “Walmart”-д ямар үр дүн авчрах бол. Энэ орныг, дэлхий ертөнцийг хүн бүхэнд зориулсан илүү сайн, сайхан газар болгохын төлөө бид өөрсдийн бүх нөөц, бололцоогоо дайчилж чадсан болов уу. Хэрэв бид үүнийг хийж чадахын зэрэгцээ бизнесээ улам хүчирхэгжүүлж чадвал юу болох бол” гэсэн юм.

Дээрх асуултууд удирдлагын зүгээс стратегийн шийдвэр гаргахад хүргэсэн бөгөөд зорилго нь биднийг хөтлөн аваачиж болох тэрхүү газар руу илгээх. Үүнтэй холбоотойгоор илүү сайн байсны дүнд хамгийн том өөрчлөлт гарч ирэх боломжтой тэрхүү газрыг олох, үүнийг хэрэгжүүлэх боломжийг бидэнд олгох соёлын

үрийг тарих үүргийг миний бие хүлээсэн.

Уг ажлын хүрээнд бид байгууллага, компаниудыг зөвхөн өөрсдийгөө хамгаалагч бус, санал, шүүмжлэлийг сонсдог болохыг уриалж эхэлсэн. Мэдээж үүнийг эхлүүлэхэд амаргүй байсан. Гэхдээ суралцах боломжтой зүйл гэдэг нь тодорхой байлаа. Ингэснээр ширээний ард 10 төрийн бус байгууллагын удирдлагатай уулзаж, тэдний 100 гаруй жилийн туршид хуримтлуулсан арвин туршлагаас суралцах боломж бидэнд олдсон юм.

Бид байгаль орчинд ээлтэй тогтвортой хөгжил, эмэгтэйчүүдэд эдийн засгийн эрх, эрх чөлөө өгөх болон эрүүл хоол, хүнс зэрэг чухал салбарт томоохон зорилтууд тавин ажилласаар ирсэн. Тухайн үед эдгээр зорилтод хэрхэн хүрэхээ ч бид мэдэхгүй байв. Судалгаа хийсний дүнд зорилго, зорилтууд нь тухайн байгууллагын дотроос урган гардаг болохыг бид баттай олж мэдсэн юм. Тухайлбал, танай компани эмэгтэй удирдлагатай компаниудаас 20 тэрбум ам.долларын хөрөнгө босгох шаардлагатай боллоо гэж бодъё. Үүний тулд бизнесийн талаар илүү сайн мэддэг хүнээр боломжит зах зээл хаана буйг олж тогтоолгох хэрэгтэй болно. Мөн өөр нэг ажилтан хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаарх тоон үзүүлэлт, тооцооллыг гаргах шаардлагатай. Үүний дараа гүйцэтгэх захирал таатай нөхцөл бүрдүүлэх хэрэгтэй болно. Яг л “Walmart”-ийн гүйцэтгэх захирал Майк Дюкийн хийсэн шиг. Гэхдээ энэ нь заавал гүйцэтгэх захирал аль эсхүл өөр хэн нэгний хийх ёстой ажил гэсэн үг биш. Энэ бол хүн бүрийн хүлээх үүрэг юм. Өнөөдөр бараа, бүтээгдэхүүн худалдан авагч хүн бүр ерөнхийдөө тогтвортой хөгжил болон эмэгтэйчүүдэд эдийн засгийн эрх, эрх чөлөө олгох тал дээр ахиц, дэвшил гаргахыг уриалсан чиг хандлагатай болжээ. Эцсийн эцэст хамгийн их нөлөөллийг олж авах зорилгоор бид өөрсдийн ажил хэргээ явуулдаг арга барилаа 360 хэм эргүүлж чадсан. Үүнд бүх сүлжээ дэлгүүр, хэрэглэгчид, олон нийт болон ажилтнуудыг хамруулсан юм.

Дээрх зарчмууд нь бидэнд сайн үр дүн өгсөн. Өөрөөр хэлбэл, нийгэмд тулгамдаад буй асуудалд гар, бие оролцох нь бизнесээ улам хүчирхэг болгоход маш тохиромжтой гэдгийг бид өөрөөл бусдад үлгэрлэн харуулж буй хэрэг. Ачааны автомашины баазаа өргөтгөж, дэлгүүрээс гарах хог, хаягдлыг дахин боловсруулан ашиг олдог болгосон. Ингэснээр манай компанийн ашиг, алдагдлын харьцаа илт сайжирч байгаа. Мөн туршлагатай ахмад хүмүүсийг ажилд авснаар хүчтэй манлайлагчид гарч ирэх болсон. Сүүлийн үед эрчим хүчний талаарх санаачилгыг хэрэгжүүлж эхэлснээр цаашид жилд нэг тэрбум ам.доллар хэмнэх боломж нээлттэй байна. Эмэгтэй удирдлагатай компаниудаас илүү их худалдан авалт хийснээр олон нийтээс хүчтэй дэмжлэг авахын зэрэгцээ цаашид хэрэглэгчдэд илүү тохирох бараа, бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд түлхэц болох давуу талтай.

Сүүлийн үед “Walmart” сүлжээ дэлгүүрийн талаар сайн, сайхан зүйл нэлээд сонсогдох болсон. Гэхдээ энэхүү амжилтын гол шалтгаан нь бодит өөрчлөлт хийсэн түүхтэй холбоотой юм. Иймээс миний зүгээс та бүхэнд доорх зөвлөгөөг өгч байна. Үүнд:

Хэрэв танай компани олон нийтийн шүүмжлэл, эсэргүүцэлтэй нэгэнт тулгарсан бол юуны түрүүнд тэдний эсрэг дуугаа өндөрсгөх гэж бүү яараарай. Зөвхөн сонсохоо л больчих. Тэгээд компаниа илүү сайн болгож, сайжруулахын тулд бүхий л нөөц, боломжоо дайчлан ажиллаарай.

“Harvard Business Review” сэтгүүлээс орчуулав.



ШИНЭ ТЕХНОЛОГИ

APPLE IOS 7: САНАХ ЗҮЙЛС

Б.БЯМБАДОРЖ

“Apple” компани iPhone гар утасныхаа хамгийн сүүлчийн үйлдлийн системийн хувилбарыг гаргав. Тэр iOS7–г нийт хэрэглэгчдэдээ зориулсан юм. Энэ хувилбар нь тус системийн долоо дахь шинэчлэлт юм. Одоогоор Apple төхөөрөмж хэрэглэгчдийн 50 –иас илүү хувь нь шинэ iOS 7 систем рүү шилжжээ. Та тэдгээр хэрэглэгчийн нэг нь ч байж магад. Мэдээж ямар нэг шинэ зүйлийг өөлөх тохиолдол байдаг. Гэхдээ шинэхэн системдээ хэрхэн дасан зохицох тухай эндээс сонирхоорой.

Энэхүү үйлдлийн системийн хамгийн содон зүйл нь илүү график дүрс ашигласан цэс юм. Утасны программын зургаас эхлээд цагны сэрүүлэг хүртэл бүх программын хэрэглээ, таних тэмдгүүд өөрчлөгдсөн. Энэ нь Apple төхөөрөмжийг хэрэглэхэд илүү тааламжтай болгосон хэрэг.

Эсвэл та хараахан шинэ үйлдлийн систем рүү шилжээгүй байгаа бол энэ сонголтыг хийхэд дараах зүйлсийг мэдээд авахад илүүдэхгүй. iOS 7 – гийн тухай хэлэх олон сайхан зүйл байгаа ч санаж явах юм их бий.

iOS 7 хэрэглэгчид

Шинэ үйлдлийн системд дасах амаргүй. Харин энэ үйлдлийн системд iOS 6 –тай харьцуулахад өөрчилж болох олон зүйл байгаа. Жишээлбэл шинэ, хөдөлгөөн ихтэй график дизайн нь зарим хүмүүсийг толгой эргэх, дотор муухайрах, нүд харанхуйлах зэрэгт хүргэж байсан. Тиймээс энэ тохиргоог нь унтраах боломжтой болгосон. Мөн ямар нэг дугаарыг хэрэглэгч рүүгээ залгаж, мессеж бичих боломжгүй болгох тохиргоонууд шинээр нэвтэрчээ.

Таны нүдэнд үзэгдэхгүй ч тус үйлдлийн систем нь аюулгүй байдлын хувьд хуучин iOS6 –аас хамаагүй илүү юм . Энгийн жишээ дурьдахад “утасны хувийн мэдээлэл цацах” (Ad Tracking) тохиргоо нь автоматаар унтраастай байдаг. Энэ тохиргоо нь ихэвчлэн худалдаа, зар сурталчилгааны байгууллагуудад хэрэглэгддэг. Таны утсаа (төхөөрөмжөө) хэрэглэж байгаа байдал, ихэвчлэн ордог интернэт хаяг зэрэг мэдээллүүд дээр үндсэлж сонирхлыг чинь тодорхойлон чухам ямар зар сурталчилгаа танд зохистой гэдгийг сонгон үзүүлдэг. Энэхүү тохиргоо нь iOS 6 систем дээр анхнаасаа асаалттай байдаг. Өөрөөр хэлбэл, хэрэглэгч нь тус тохиргоог унтраагаагүй. Эсвэл ийм зүйл байдаг гэдгийг ч мэдээгүй бол тодорхой хэмжээний хувийн мэдээлэл танихгүй хүмүүсийн гарт орсон гэсэн үг юм.

iOS 7 нийтийн хэрэглээнд гарснаас хойш “Apple” компани нэг сарын хугацаанд албан ёсоор iOS 6 руу буцах боломжийг хэрэглэгчиддээ олгосон. Харин одоо iOS 6 руу шилжих боломжгүй. Гэхдээ өнөөдрийн интернэт хөгжсөн цагт ямар ч зүйлийг хийж болно шүү дээ. Эрэлт нь байвал хэрэгцээ нь байж л таарна. Гэхдээ хэрэглэгч ямар нэгэн “сэжигтэй” аргаар iOS 6 руу буцаад шилжсэн тохиолдолд Apple албан ёсоор дэмжихгүй мөн бүтээгдэхүүний баталгаат хугацаа (хэрвээ тухайн хэрэглэгчид хамаарах бол) цуцлагдах юм.



iOS 6 хэрэглэгчид

Хэрэв та арай шийдэж чадаагүй, эргэлзэж байгаа бол дараах зүйлд анхаарлаа хандуулаарай.

Одоогоор зарим Apple төхөөрөмжийн программууд iOS 7 дээр алдаатай ажилладаг, эсвэл огт ажилладаггүй. Иймээс та буцах боломжгүй сонголт хийхээсээ өмнө өөрийн хэрэглэдэг толь, программуудыг судалж, iOS 7 хувилбар нийтэд гарсан эсэхийг сайн шалгаарай.

iPhone 4 гар утастай хэрэглэгчдэд анхааруулахад iOS 7 суулгасаны хэрэггүй. Суулгасан тохиолдолд утасны үйлдэл удааширч, программуудыг хэрэглэхэд бэрхшээлтэй. Ер нь бараг хэрэглэх боломжгүй. Учир нь тус утас нь iPhone 4S, 5 зэрэг дараагийн үеийн загваруудаас бага хүчин чадлын процессортой юм. iOS 7–г суулгаж болох утаснууд iPhone 4 загвараар хязгаарлагдаж байгаа. Гэхдээ тийм утсанд iOS 7 суулгах нь таагүй үр дүнд хүргэх юм. ■



МОНГОЛД АНХ УДАА
"ИХ ХАРАНГА" КОМПАНИЙН
ЗАХИАЛГААР ТУРК УЛСАД
УЙЛДВЭРЛЭГДСЭН
"ИЛЧГАЗ"

ГАЗНЫ ҮНЭ 62'500₮
ХОШУУ 15'000₮
ДАХИН ЦЭНЭГЛЭЛТ
5500₮

5 ЛИТРИЙН
БАГТААМЖТАЙ

18-20 ЦАГ
ТАСРАЛТГҮЙ АСАХ
ХҮЧИН ЧАДАЛТАЙ

ХЭРЭГЛЭХЭД ХЯЛБАР
АЮУЛГҮЙ
АВСААРХАН

ДАХИН ДАХИН
ЦЭНЭГЛЭЖ АШИГЛАХ
ЗОРИУЛАЛТТАЙ



ГАЗЫН НЭМЭЛТ
ХОШУУ
3 МЕТР



ХАРЬЦУУЛАЛТ

Хаяг: Улаанбаатар хот–28, ш/х–44/685,
УБ–210664 Энхтайвны өргөн чөлөө 17/3
Алтай центр 6 давхар 610 тоот
Вэб хаяг: www.Logo3s.mn www.reclam6s.mn
Утас: (976) – 70100156; 91116586; 91116587;
96616586; 96011792; 96011794
Факс: (976) – 70100156
И–мэйл: Ikharanga2@gmail.com


ТӨСӨВ

ТОДОТГОЛД ЯАРСАН ТӨСӨВ

Б.БАЯРТОГТОХ

Монгол Улс далайд гарах гэж буй хөлөг онгоц юм. Онгоцны ахмад нь Засгийн газрын тэргүүн Н.Алтанхуяг. Түүний удирдаж буй баг нь шинэчлэлийн гэх тодотголтой. Тиймээс ирэх оны төсөв урьд оныхоос арай өөр байх ёстой. Тэд “авлигажсан төсөв”-өөс сална гэж мэдэгдсэн. Гэтэл төсвийн сахилга батыг сайжруулах, олон жилийн буруу хандлагыг өөрчлөх Ерөнхий сайдын мэдэгдэл ирэх оны төсөвт тусгалаа олсон эсэх нь эргэлзээ төрүүлсээр. Нэг талаасаа баталсан даруйдаа тодотгол хийхээр болсон нь анхны тохиолдол болж байна. Нөгөөтэйгүүр төсөвт тодотгол оруулах нь төдийлэн үр дүнтэй арга биш гэдгийг зарим эдийн засагч хэлдэг. Төсөвт ийн яаран тодотгол хийх болсон нь төлөвлөлтийн алдаа гэж үзэх нь ч бий. Уг нь тэвчиж болох урсгал зардлыг хэмнэх. Үр ашиггүй хөрөнгө оруулалтыг төсөвт тусгахгүй байх замаар зардлын тэлэлтийг хязгаарлах учиртайг Үндэсний аудитын газраас хийсэн төсөвт өгсөн саналдаа тэмдэглэжээ. Ингэснээр захиргааны зардлыг бууруулж, хөрөнгө оруулалтын зардлаа нэмэгдүүлэх боломжтой гэж үзсэн.

Засгийн газрын ирэх оны төсөвт УИХ-ын зарим гишүүн сэтгэл дундуур үлдсэн. Тэд баталчихсан хэрнээ ийн гонсгор байгаа нь сайн төсөв батлаагүйн нотолгоо болж мэдэх. Тэр тусмаа УИХ-ын гишүүн, Эдийн засгийн байнгын хорооны дарга Б.Гарамгайбаатар “Томоохон бүтээн байгуулалтыг олноор нь царцаасан, Ч.Улаан сайдын хэлдгээр шахсан бяслаг шиг төсөв хараахан болж чадсангүй” гэв. Харин өнгөрсөн нэг жилийн хугацаанд 1.5 тэрбум ам.доллар буюу 2.5 их наяд төгрөгийн хохирол амссан эдийн засагт нийцсэн төсөв боллоо гэж УИХ-ын гишүүн Н.Батцэрэг дүгнэсэн. Энэ оны улсын төсвийн орлого 1.2 их наядаар тасарсан нь ирэх жилийн төсөвт сургамжтай байв. Гэхдээ урсгал зардлаа танах бус хөрөнгө оруулалтын зардлаа “гээсэн” нь шинэхэн төсөвт дахин тодотгол хийхэд хүргэсэн нь энэ. Иймээс УИХ-ын даргын хэлснээр ирэх оны 2-3 сард төсөвт тодотгол оруулах бололтой. Гэхдээ “чамлахаар чанга атга” гэсэн үг бий. Ирэх онд 1.1 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт улсын хэмжээнд хийгдэх юм. Гол нь хөрөнгө оруулалтын



хамрах хүрээ, чанар ямар байхаас ирэх оны төсвийн өнгө шалтгаална.

“Сонгодог зээл”

“Долоо хэмжиж, нэг огтлох” үүрэгтэй ирэх оны төсвийг дордуулсан гэх яриа ч Төрийн ордонд байна. Ирэх онд манай улсын төсвийн нийт орлого 4.6 их наяд төгрөг байх юм. Харин зарлага нь 5.5 их наяд. Өнгөрсөн 13 жилийн хугацаанд төсвийн орлого 15 дахин өссөн нь энэ. Харин төсвийн алдагдлыг нөхөхийн тулд 1.4 их наяд төгрөгийн

үнэт цаас гаргахаар тооцжээ. Ихэнх тохиолдолд Засгийн газрын үнэт цаасыг Монголбанк худалдан авч, оронд нь төгрөг нийлүүлж ирсэн байдаг. Энэ нь эдийн засагт төдийлэн үр дүнтэй арга биш гэдгийг учир мэдэх мэргэжилтнүүд сануулж ирсэн. Үнэт цаас худалдах нь шулуухан хэлэхэд Засгийн газар Төвбанкнаасаа зээл авч байгаа "сонгодог" хэлбэр юм. Харин хөрөнгө оруулалтын тодорхой хэсгийг Засгийн газар гадаадын төслийн зээл авах замаар санхүүжүүлэхээр тогтжээ. Засгийн газрын хувьд огт мөнгөгүй биш. Төсвийн гадуурх санхүүжилтийг хангалттай дэмжиж буй. Тиймээс ирэх оны төсөвт хөрөнгө оруулалтын зардлыг танасан нь нэг талаасаа зөв алхам гэдгийг зарим эдийн засагчид хэлж байна. Хөгжлийн банкны 580 сая ам.доллар, Чингис бонд гээд Засгийн газрыг чинээлэг "айл" гэж дүгнэж болох юм.

Сануулга


Дэлхийн банкны зүгээс төсвөөс гадуурхи санхүүжилт хэрээс хэтэрч байгааг онцолж, Хөгжлийн банкны зарлагыг төсөвт оруулж тооцох ёстой гэж байр сууриа илэрхийлсэн. Тус банкны хувьд "Чингис бонд"-ын хөрөнгийн нэлээд хэсгийг өөрийн дансаар дамжуулж буй. Засгийн газар 900 сая ам.долларыг одоогоор бондоос зарцуулаад байна. Хэрэв төсөвт Хөгжлийн банкны зарцуулалтыг оруулж тооцвол энэ онд алдагдал ДНБ-ий 12 хувийг эзлэхээр байгаа. Үүнийг Дэлхийн банкнаас хагас жил тутам гаргадаг "Монгол Улсын эдийн засгийн улирлын тойм"-д дурджээ.

Сангийн сайд Ч.Улаан "Улсын их хурал иж бүрэн төсөв баталсангүй. Тухайлбал, хөгжлийн бүтээн байгуулалтын эх үүсвэр босгох асуудлыг ирэх оны төсөв дээр суулгаагүй. Ингэснээр ирэх жил шинээр бүтээн байгуулалтад эх үүсвэр татах бололцоогүй болж байна" гэв. Нэг талаасаа үе үеийн Сангийн сайд хэзээд "баян" байхыг мөрөөддөг. Тэр утгаараа төсвийн зарлагад үрэлгэн хандах нь бий. Тиймээс Сангийн сайдын санаанд нийцнэ гэвэл амаргүй хэрэг. Гэхдээ төсвийн алтан зарчим гэж бий. Үүний жишгээр хэчнээн орлого багассан ч хөрөнгө оруулалтад тодорхой хэмжээний "хувь" үлдээх ёстой. Харин урсгал зардлаа танаж, аль болох хөрөнгө оруулалтаа мөнгөтэй үлдээх учиртайг Сангийн сайд асан Д.Даваасамбуу өгүүлсэн.

Хөрөнгө оруулалт яагаад чухал гэж...

ДНБ-ий эзлэх Засгийн газрын өр 8.4 их наяд төгрөг. Энэ нь ДНБ-ий 49.5 хувьтай тэнцэж байна. Энэ тохиолдолд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан өрийн хэмжээг хязгаарлах нь зүйтэйг УИХ дахь МАН-ын бүлгийн гишүүд хэлж буй. Гэхдээ хөрөнгө оруулалтын зардлыг танасан нь Засгийн газарт халгаатай. Иймээс ирэх онд тодотгол хийх замаар төсөвт хөрөнгийн зардлыг суулгах аж. Энэ онд Засгийн газар хөрөнгө оруулалтын зардлаа 70 хувиар тасалсан. Тиймээс ирэх онд орлого хэр бүрдэхээс хөрөнгө оруулалтын зардлыг санхүүжүүлэх боломж бүрдэх юм.

Урсгал зардлын бүтэц 2000-2013 оны байдлаар



Бараа үйлчилгээний бусад зардлын бүтэц 2000-2013 он




Төсөвт хөрөнгө оруулалтын зардлыг УИХ гурван сарын хугацаагаар тасалж, тухайн ажлуудад аудитын шалтгалт оруулахаар болсон. Нэг талаасаа төсвийн хөрөнгө оруулалтад бодитой судалгаа хийж, хөрөнгийн хэмжээг УИХ-аар дахин хэлэлцэх гэж байгаа нь энэ. Мөн төсөвт суусан ажил хийгдэхгүй байх шалтгааныг орлого бүрдээгүй гэж шууд хэлэх нь өрөөсгөл юм. “Хэргийн эзэн” нь зураг төсөвгүй, тендер зарлаж чадаагүй гэх захиргааны хариуцлагагүй байдал ч нөлөөлж байгааг энд тэмдэглэе.

Нэмэгдэл

Засгийн газрын зарлага 2010 онд 36.6 хувь байв. Энэ нь огцом өсч ДНБ-ий 47 хувьд хүрэхээр байна. Тэгвэл энэ байдал ирэх онд ялимгүй засал авч магадгүй нь. Гэхдээ Засгийн газарт үйл ажиллагааны зардлаа бууруулах эр зориг алга. Эдийн засаг хүнд. Төсвийн орлого 100 хувь бүрдэх эсэх таамаг тодий. Ийм нөхцөлд ирэх оны төсөв хэрэгжинэ. “Нээлттэй нийгэм форум”-аас хийсэн судалгаанд “Коксжих нүүрсний экспорт таван сая тонноор буурсан тохиолдолд төсвийн орлого 100 тэрбум төгрөгөөр тасрах эрсдэлтэй” гэжээ. Ирэх онд манай улс нийтдээ 31.4 сая тонн нүүрс экспортлохоор төлөвлөж буй.

Үнийн өсөлт, валютын ханшийн чангарал нийт эдийн засагт амсхийх чөлөө өгөхгүй нь. Гэсэн ч УИХ ирэх онд 160 гаруй мянган төрийн албан хаагчийн цалинг нэмэгдүүлэхээр болсон. Ингэснээр төрийн албаныхны цалин 10 хувиар өсөх юм. Зөвхөн төрийн албан хаагч гэхгүйгээр тэтгэврийн хэмжээг бас нэмж байгаа. Өдгөө 180 мянган төгрөгийн тэтгэвэр авдаг иргэнийх 200 мянга болох аж. Нэг талаасаа инфляцийн өсөлтийг цалин, тэтгэврийн нэмэгдэл нөхнө гэсэн үг. Энэ нь иргэдэд “бэлэг” болох ч эдийн засагт шил шилээ дарсан олон асуудлыг дагуулж мэдэх юм. Монгол Улсын ирэх оны төсвийг жинхэнэ албан ёсны гэж хэлэхэд эрт байна. ■

2014 оны нэгдсэн төсвийн зарлагын бүтэц




Дэлхийн улс орнуудын ДНБ-ий өсөлт

	2008	2009	2010	2011	2012	2013*	2014**
Дэлхийн нийт өсөлт	2,7	-0,4	5,2	3,9	3,2	2,9	3,6
АНУ	-0,3	-2,8	2,5	1,8	2,8	1,6	2,6
Европын холбоо	0,4	-4,4	2,0	1,5	-0,6	-0,4	1,0
Япон	-1,0	-5,5	4,7	-0,6	2,0	2,0	1,2
Монгол	8,9	-1,3	6,4	17,5	12,4	11,5	14,8

Эх сурвалж: ОУВС-ийн тайлан

Монгол Улсын нэгдсэн төсөв, тэрбум төгрөг



Эх сурвалж. Эдийн засгийн хөгжлийн яам

ҮЗЭЛ БОДОЛ

ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ ХИЙГЭЭД БУУДАЙ

Ж.Гөлгөө (*Эдийн засагч*)



Аливаа улс орны аюулгүй байдлын нэг бүрэлдэхүүн нь хүнс тэжээлийн баталгаат хангамж байдаг. Хүн амын уламжлалт хэрэглээний болон дотооддоо хямд үйлдвэрлэдэг хүнсний бүтээгдэхүүн энэ үүргийг гүйцэтгэдэг. Тиймээс Япон, Тайланд зэрэг улсад цагаан будааг, Турк, Орост бол буудайг нөөцөлдөг. Түүхийг мөшгивөөс ийм барааны хангамж нь гаднаас хамаарал багатай байхыг улс орнууд эрхэмлэн иржээ.

Дээрх шалгууруудыг бодолцвол манай стратегийн гол хүнс нь мах баймаарсан. Хямд өртөг талаасаа ч, үйлдвэрлэл нь үндэсний хэмжээнд жигд тархсан талаасаа ч тэр. Гэвч 1960-аад онд газар тариалан эрхлэн хөгжүүлснээс хойш хүнсний аюулгүй байдлыг үр тариатай холбож ирсэн. Чингэснээр дан мал аж ахуйд бус, бас газар тариаланд тулгуурлах боломж гарав. Үүнийг “унаа, хөтөлгөө хос морьтой” болсонтой зүйрлэх сайн хэрэг. Хадгалах, тээвэрлэх, түгээхэд хялбар учраас үр тарианд стратегийн ач холбогдол өгөхөд буруудах ч үгүй биз.

Монголын нөхөн үйлдвэрлэлийн бүтэц, загварт зарчмын өөрчлөлт гарч буй. Ийм цаг үед стратегийн хүнсний үзэл баримтлалаа цэгцлэн тодотгож, зарим чиглэлийг нь эргэж нэг харахаар болсон. Юуны өмнө газар тариаланг дэмжих бодлогод хамаарах өртөг зардлын талаас нь дүн шинжилгээ хийж үзмээр. Жилд 114 сая тонн буудай хураж дэлхийд тэргүүлдэг өмнөд хөрш нэг га-гаас дунджаар 47 центнер /цн/ ургац хураадаг. Тэгвэл 60 сая тонныг хураж гуравт жагсдаг хойд хөрш га-гаас 23 цн-ийг авч байна. Монгол Улс өнгөрсөн онд 15,3 цн, энэ жил 14 цн буудай авсан. Бүтээмж нь Хятадынхаас гурав дахин, Оросынхоос бараг хоёр дахин доогуур гэсэн үг. Эдгээр тоо баримт нөгөө талаасаа өртөг зардлынх нь тусгал болох нь мэдээж. Зээлийг нь хүчингүй болгох, хөнгөлөлттэй үнээр техник, үр бордоо олгох. Түлшийг зээлээр хангах, хүүгүй зээл өгөх гэх зэрэг олон төрлийн хөнгөлөлт, дэмжлэгийг бид сүүлийн 20-иод жил газар тариаландаа үзүүлсэн. Шууд болон дам эдгээр татаасыг нэгтгэн тооцож үзсэн болов уу?... “Хүн амын гол хүнс” гэдэг сүржин уриагаар далайлгасаар, ямар ч үнээр болов талх тариатай байх сэтгэлгээнд ижил дасал болцгоосон, бид. Болзолт рефлексийн хэмжээнд хүртлээ дадсан гэхэд хилсдэхгүй. Эл уриа сүүдэр талдаа “мөнгө босгох” сувгийг Тариалан эрхлэлтийг дэмжих сан, гурилын үйлдвэрүүд, Улсын нөөц зэрэг сүлжээгээр дамжуулан үүсгэсэн.

Гурилын үйлдвэрт тушаасан тонн буудай бүрт сүүлийн хоёр жилд »

100 мянган төгрөгийн урамшуулал олгож буй. Нийт ургацын гуравны хоёр нь төвлөрсөн бэлтгэлд хамрагдана гэвэл 30 гаруй тэрбум төгрөг болно. Тонныг нь өнөөдрийн дэлхийн зах зээлийн ханшаар буюу 250 ам.доллараар импортолно гэж үзье. Тэгвэл 85 мянган тонн буудай буюу үндэсний нийт хэрэгцээний 20 хувийг энэ урамшууллаар хангахад хүрэлцээтэй санхүүжилт. Энэ онд буудайг 360-420 мянган төгрөг буюу дунджаар 280 орчим ам.доллараар улс худалдан авч буйг Үйлдвэр, хөдөө аж ахуйн дэд сайд мэдэгдсэн. Дээр нь өнөөх 100 мянгын урамшуулал, хадгалалт, тээвэрлэлтийн зардал нэмэгдэнэ. Үүний дүнд монгол талх олон улсынхаас илт давуу өртөгтэй болдог.

Газар тариалан дахь шалгарал үндсэндээ дуусгавар болж, тэсэж үлдсэн компаниуд нь хөл дээрээ бараг босчихлоо. Өнөөгийн ийм нөхцөлд үр тарианд олгож буй дэмжлэг, татаасыг зохих хэмжээгээр хумих хэрэгтэй байх. Тэгэхдээ зардлын хувьд өрсөлдөх боломжгүй сум, аж ахуй, тариаланчид өөр тарималд, эсхүл өөр салбарт шилжих нөхцлийг хангах үүднээс шүү. Энэ ажлыг эртнээс мэдээлж, ил тод, үе шаттайгаар зугуухан хэрэгжүүлэх ёстой нь мэдээж. Урамшуулал хөнгөлөлтийн төрөл, хувийг ил тод бас тогтвортой болгоё. Мөн тоо хэмжээг нь нийтэд тайлагнах тогтолцоог ч сайжруулах хэрэгцээ буй. Төмс, хүнсний бусад ногоо ч хүнсний хангамжид чухал нөлөөтэй. Тиймээс урамшууллын тогтолцоонд тэдгээрийг хамруулах механизмыг бий болгох нь зөв. Хүнсний аюулгүй байдлыг заавал буудайгаар биш заримыг нь зардал багатай бусад таримлаар хангах үүднээс тэр. Хэрэглээний загвар тогтмол гэхээсээ илүү түүхэн ойлголт биз, 1960-аад оноос өмнө монголчуудын хүнсэнд үр тариа ялимгүй хувьтай байсан нь ойлгомжтой. Гурилын үнийг бодит түвшинд нь жинхэнэ өртгийнх нь хэмжээнд тавиад ирвэл өөр төрлийн орлох бүтээгдэхүүн оронд нь гараад ирэх биз. Зарим оронд тариалж буй талбайд нь уялдуулж урамшуулал өгдөг. Энэ нь нэгжийн гарц, зах зээлд нийлүүлэлтийг хөхиүлэх тал дээр дутагдалтай. Гэхдээ хүнсний хангамжийг нэмэгдүүлэх ач тустай. Хэрэг дээрээ гэр бүл, тосгон суурины дотоод хэрэгцээнд зориулагдаж буй ногоо ч ийм дэмжлэгт хамаарна гэсэн үг.

Өөр нэг асуудал гэвэл үндэсний газар тариаланг дэмжиж буй тогтолцоогоо бид илүү уян хатан, хөрш зах зээлтэй харилцан үйлчлэлтэй болгомоор санагддаг. Ухаан нь тариалангийн бүсээс алслагдмал Баян-Өлгий аймагт гадаад гурил хэрэглэх нь төвийн бүсээс татаж авснаас арай хямд байхуйц гаалийн татвар үйлчлэх ёстой. Үүний нэг адил илүүдэл үр тариаг гадаадад гаргах нь боломж ч нээлттэй байх ёстой. Ер нь Тариалан эрхлэлтийг дэмжих санг тарианы үндэсний хангамж балансыг бүхэлд нь хариуцаж экспорт импортын шуурхай ажиллагаа явуулах эрх бүхий төрийн өмчийн компани болгоход тохирно. Орон нутагт арилжааны үндсэн дээр зоорь агуулах түрээслэх, тээвэр-борлуулалтын сүлжээг ч гэрээгээр ажиллуулах боломжийг ч улсын өмчлөлийн эл компанид олгоно.Харин санхүүгийн тайланг нь нийтэд ил байлгах ёстой. Гурил үйлдвэрлэгчдийн зүгээс тогтоох гэж үе үе оролддог монопол, үнийг захиргааны биш, эдийн засгийн аргаар цохих боломж ч нэмэгдэнэ.

Хүнсний баталгаат хангамжийг бүрдүүлэхдээ биет байдлаар нь үйлдвэрлэх, нөөцлөх биш юм. Харин зоос мөнгөө базаачихаад шуурхай нийлүүлдэг аж. Энэ зарчмаар ажилладаг практикийг сүүлийн үед дэлхийн улс орнууд түлхүү хэрэглэх болж байна. Ер нь хямд төсөр хувилбар гэнэ. Яагаад гэвэл урт хугацаагаар үргэлжилдэг дайн байлдаан, бүслэлт хаалтын шинжтэй хориг саад эдүгээ багассан. Ган гачиг, үер бороо, осол аваар зэрэг түр зуурын гамшгийг даван туулах хэрэгцээ л гол төлөв үүсэх болсон. Нөгөөтэйгүүр улс дамнасан тээвэрлэлтийн технологи боломж сайжирсан учраас тэр. Оросын Алтайн хязгаар, зүүн Казахстан болон Дорнод Хятад гэх Азийн үр тарианы тэргүүлэх “ гурван сагс”-ны дунд бид оршдог. Тиймээс “зоос базаах” арга манайд бүр ч зохистой хувилбар байж мэднэ. Буудайн нийт хэрэгцээнийхээ дөрөвний гурав орчмыг л дотооддоо баталгаатай үйлдвэрлээд бусдыг нь бүс нутгийн худалдаагаар хангавал зохилтой. Тэр нь бидний хувьд зардал багатай хувилбар байх болов уу. Тансаг, өвөрмөц зориулалтын гурилын импортыг байнга нээлттэй байлгая. Харин гаалийн татвар өндөрхөн тогтоож тусгай санд хуримтлуулах хэрэгтэй. Түүнээ эргээд газар тариаландаа хэрэглэхэд болохгүй зүйл үгүй санагдана.

Нөгөө талаас газар тариаланд олгож буй татаас нь хүнсний хангамжийн баталгааг хангах зориулалттай гэхээсээ үндэсний үйлдвэрлэлээ дэмжих зорилготой байдгийг бид анзаарах ёстой. Жишээ нь Европын холбооны “Нийтийн сан” юуны өмнө АНУ, Туркийн хямд үр тарианаас зах зээлээ хамгаалахад чиглэгдсэн байдаг. Гэхдээ өмгөөлөлдөө авах дотоодын үйлдвэрлэл нь боломжийн өртөгтэй байх шаардлагатай. Монгол орны нутаг дахь Азийн тэгш өндөрлөг нь хуурай, дулааны улирал нь богино, хөрсний шим муутай. Тийм газартаа тариалан эрхлэх нь тун ч эрсдэлтэй бизнес болно. Иймд төр засгаас энэ салбарыг дэмжих нэг чухал хэлбэр нь хандив татаас гэхээсээ илүү даатгалын үндэсний тогтолцоо байх ёстой. Бүх төрлийн таримлыг албан журмаар даатгах нь “эрсдэлтэй тариалалт”-ын бүсийн хувьд орно. Дээрх 100 мянгын урамшууллаас чухаг зүйл гэхэд хэтрүүлэг болохгүй.

Харин мах үйлдвэрлэл манай байгаль цаг уурт зохицсон, илчлэгийн агууламж нь өндөр, өртөг нь ч өрсөлдөхүйц билээ. Иймд энэ бүтээгдэхүүнд стратегийн нөөцийн статусыг нь олгох. Улмаар хүнсний аюулгүй байдлын нэг тулгуур болгох бодлого үгүйлэгдэж байна.

Хүнсний аюулгүй байдлын хүрээнд илчлэгийн наад захын хэрэгцээг хангах, эрүүл ахуйн стандартын асуудал бас багтана. Энэ тухайд өгүүллийнхээ хүрээнд хөндөөгүй болохыг өчсү. ■

ОЮУТОЛГОЙ

ХҮЧИРХЭГ АЖ ҮЙЛДВЭРИЙГ ХӨГЖҮҮЛЬЕ

Б.ЭРДЭНЭ

“Metals Mongolia-2013” хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт /2013.11.08/ хоёр дахь удаагаа нэлээд онцлогтой болсныг “Оюутолгой”-н тухай бичихээс өмнө дурдмаар байна. Тус чуулганы зорилго нь хүчирхэг аж үйлдвэрийг хөгжүүлэх байсан учраас “Оюутолгой”-той уялдаж байгаа юм. Нэг үгээр хэлбэл, олборлох уул уурхайгаас боловсруулах уул уурхайн салбарт шилжсэн гэдгийг илүү тодотгож байв. Ингэснээр Монголд орж ирж буй гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэх нөхцөл бүрдэх юм. Түүнчлэн хариуцлагатай уул уурхай хөгжих бололцоог хангах аж.

Нэг талаасаа зөвхөн ам.доллар гэж хөрөнгө оруулалтыг сэтгэх нь өрөөсгөл. Хөрөнгийн урсгалыг дагаад шинэ технологи, шилдэг арга туршлага, соёл, стандарт нэвтрэх давуу талтай. Үүний жишээ гэвэл “Оюутолгой”-г хэлж болох юм. Хэдий хөрөнгө оруулалтын гэрээг тойрсон маргаан улс төрийн түвшинд тасралтгүй өрнөж байгаа ч эдийн засагт оруулах хувь нэмэр нь үлэмж цараатайг гэрчилсээр. Хэрэв “Оюутолгой” төслийн хөрөнгө оруулалтын гэрээг батлаагүй. Өнөөг хүртэл асуудал сунжирсан бол эдийн засагт ийм огцом үсрэлт гарахгүй байсныг эдийн засагч Ж.Үнэнбат хэлсэн. Мөн одоо үүсээд буй эдийн засгийн хүнд байдлаас ангижрах гарц нь “Оюутолгой” гэв.

Энэ жилийн “Metals Mongolia” чуулганд металлургийн чиглэлээр хэрэгжүүлэхээр төлөвлөж буй боломжит төсөл, хөтөлбөрийг “Эрдэнэс МГЛ” компанийн гүйцэтгэх захирал О.Сайнбуян танилцуулсан юм. Төрийн өмчит тус компани “Мон зэс”, “Мон алт”, “Мон төмөр” гэсэн гурван хөтөлбөрийг боловсруулсан



Фотог Б.Бямба-Очир

Бидэнд ямар боломж байна вэ

Хэмжүүр /Он	1990	2000	2013	2020	2030	2040	2050
Монгол хүн- “Олуулаа” сая	2	2.4	2.9	3.5	4.5	5.5	7
Дундаж наслалт /жил/	60	64	68	73	78	80	85
ДНБ /тэрбум ам.доллар	2.7	1.1	11	40	60	150	380
Нэг хүнд ногдох ДНБ /ам.доллар/	1.290	470	4.000	11.500	13.000	27.000	55.000
Дотоодын хуримтлал /тэрбум ам.доллар/	0.09	0.08	3.4	15	28	40	50
Хөрөнгө оруулалтын зэрэглэл	-	-	BB-	A	AA	AAA	AAA
Хуулийн засаглал	-	-	94	20	10	5	1
Өрсөлдөх чадвар	-	-	98	50	25	10	1

Эх сурвалж: Ерөнхийлөгчийн Тамгийн газар

талаараа мэдээлэл хийсэн. “Мон” гэдэг нь Монгол гэсэн утгыг агуулж байгаа. Тус хөтөлбөр хэрэгжсэн тохиолдолд манай улсын цэвэр зэсийн болон төмрийн үйлдвэрлэл одоогийнхоос хоёр дахин нэмэгдэх юм.

Монгол Улсын ДНБ-ий хэмжээ энэ оны байдлаар 17 их наяд төгрөг буюу 10 тэрбум ам.доллар. Үүнээс илүү байлгах боломж байсныг Монголбанкны Ерөнхийлөгч Н.Золжаргал хэлсэн удаатай. Түүний хэлж байгаагаар энэ онд эдийн засаг 11 хувиар өсөх аж. Ирэх онд 2011 оны /17 хувь/ өндөр өсөлтөд дөхнө гэлээ. Хэрэв Төвбанкны Ерөнхийлөгчийн таамаг нь байгаа зөв онилсон бол ДНБ-ий хэмжээ ирэх онд 20 их наядад хүрэх Сангийн яамны тооцоо биелэлээ олно гэсэн үг.

Хоёр жил тутамд нэг удаа болдог “Metals Mongolia” чуулга уулзалтад “Оюутолгой” компанийн дэд захирал Д.Мөнхбат “Хүчирхэг аж үйлдвэрийг хөгжүүлэх нь” сэдвээр илтгэл тавьсан. Тэрбээр илтгэлдээ “Бид Оюутолгойд уул уурхайн салбарын шилдэг технологийг нэвтрүүлсэн. Үүнийгээ өдөр тутмынхаа үйл ажиллагаанд ашиглаж байна. Нэг удаа 290 тонн хүдэр зөөх даац бүхий ил уурхайн Комацугаас эхлээд дэлхийд маш цөөхөн уурхайд ашигладаг блокчлон олборлох аргыг нэвтрүүлэх их хэмжээний бэлтгэл ажил хийснийг манай уурхайгаас харж болно” хэмээн онцоллоо.

“Оюутолгой” компани дэлхий дээр хамгийн бага ус ашигладаг уурхай болгон хөгжүүлэх зорилт тавьжээ. Тус компанитай ижил төстэй үйл ажиллагаа явуулдаг дэлхийн бусад уурхайд нэг тонн хүдэр боловсруулахын тулд 1.27 шоо метр ус ашигладаг гэсэн судалгаа бий. Харин “Оюутолгой” компани орчин үеийн усны хэмнэлт бүхий технологийг нэвтрүүлсэн. Ингэснээр уурхай энэ оны эхний хагас жилийн дундаж дүнгээр боловсруулж буй нэг тонн хүдэр тутамдаа 0.43 шоо метр ус ашигласан байна.

Бид уул уурхайг хөгжүүлэх том амбийцтай. Гэвч уул уурхайг хөгжүүлэх таатай боломжийг үгүйсгэж, хөрөнгө оруулагчдыг үргээх нь бий. Үүнээс үүдэн эдийн засаг мухардалд орж, үндэсний хөгжлийг хурдасгах уул уурхайн томоохон төсөл, хөтөлбөр гацах болсон.

Нөгөөтэйгүүр гадаадын шууд хөрөнгө оруулалт, экспортын орлого буурсан нь төсөвт томоохон эрсдэл үүрүүлсэн. Энэ нь төсвийн орлого 1.2 их наядаар тасрахад хүргэсэн. Мөн Монгол Улсын талаарх сөрөг мэдээлэл сүүлийн нэг жилийн турш дэлхийн томоохон хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацагдсан нь гадаадын хөрөнгө оруулалтыг үндсэндээ царцаасан.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж “Хөрөнгө оруулалт багасахаар үйлдвэр үйлчилгээ багасч байна. Үйлдвэр үйлчилгээ багасахаар орлого тасарч байна. Орлого тасрахаар амьдралын өртөг нэмэгдэж байна. Төрд үүнийг нөхөх боломж алга” гэж хэлсэн. Тэрбээр “Том төрөөс ухаалаг төр лүү” сэдэвт үндэсний зөвлөлдөх уулзалтын үеэр ингэж учирласан юм.

Гэхдээ Монгол Улс гал алдахгүй бас бүсээ чангалахгүй байх үндэслэл нь “Оюутолгой” компани болж байгаа. Тус компани энэ оны долдугаар сарын эхээр анхны баяжмалаа экспортод гаргасан. Тийнхүү дэлхийн зах зээлийн үнээр зэсийн баяжмалаа өмнөд хөршид нийлүүлж байна. Тус компанийн гүйцэтгэх захирал Крейнг Киннел Хонконгод болсон Монголын хөрөнгө оруулалтын ээлжит чуулганд оролцохдоо “Хэлэлцээр наштайгаар шийдэгдэх өдөр ирнэ гэдэгт итгэлтэй байна. Гэхдээ ололт амжилтыг дан ганц хурдаар хэмжиж болдоггүй. Он цагийн шалгуурыг давж чадахуйц, харилцан итгэлцсэн түншлэл дээр суурилсан илүү сайн, илүү хүчирхэг “Оюутолгой”-г бий болгосноор амжилтыг хэмжинэ” гэжээ.

“Монгол Улсад 2014-2018 онд уул уурхай олборлох, боловсруулах. Хот, дэд бүтцээ барьж байгуулах. Мөн нийгмийн хөрөнгө оруулалт хийхэд 55-84 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт шаардлагатай” гэж Худалдаа хөгжлийн банкны ерөнхийлөгч Р.Коппа онцлов. Хөрөнгийн гуравны нэгийг гадаадын хөрөнгө оруулалтаар, 28 тэрбумыг дотоодын эх үүсвэрээс, зургаан тэрбумыг бондоор, 13-ыг гадаадын хөрөнгийн зах зээлээс, 14-ийг арилжааны банкууд, хоёр тэрбумыг нь донор болон бусад эх үүсвэрээс гаргах магадлалтай гэж түүний таамагласан нь баримжаатай болохыг эдийн засагч Д.Жаргалсайхан “Монголд, хоёулаа хожъё” өгүүлэлдээ дурджээ.

Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль шинэчлэгдсэн, Үнэт цаасны тухай хууль ирэх оноос хэрэгжиж эхэлнэ. Мөн Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль батлагдсан. “Оюутолгой”-н асуудал нэг талдаа цэгцрэх гэж байгаа нь ирэх онд эдийн засаг сэргэх найдвар төрүүлсээр. 2050 он гэхэд манай улсын ДНБ-ий хэмжээ 380 тэрбум ам.доллар байх боломж бий. Ингэснээр нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ нь ойролцоогоор 54 мянган ам.долларт хүрэх юм. Мөн хөрөнгө оруулалтын зэрэглэл “AAA” болох өөдрөг ирээдүй өмнө байна. Энэ бол хамгийн өөдрөг хувилбар. Уг төсөөллийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас хийжээ. ■



Ногоон Эдийн засгийн Өсөлт

төрийн бус байгууллага

www.greengrowth.mn